

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)-ИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 (БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙН ӨРГӨТГӨЛИЙН СУДАЛГАА), ГҮНИЙ УСНЫ УДИРДЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3-ЫГ ХЯНАЛТЫН ХОРООГООР ХЯНУУЛАХ ХҮСЭЛТЭД УДИРДЛАГААС ӨГӨХ ХАРИУ

2018 оны 4-р сарын 2-нд Хяналтын хороо хүлээн авч, 2018 оны 5-р сарын 11-нд бүртгэсэн Монгол улсын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэмэлт санхүүжилт (P145439)-ийн Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 1 (Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн судалгаа), Гүний усны удирдлагыг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг 3-т хяналт шалгалт явуулах хүсэлт (RQ18/02 and 18/03)-ийг Удирдлага хянаж үзсэн болно. Удирдлагаас дараах хариуг бэлтгэсэн болно.

2018 оны 6-р сарын 13

ТАЙЛБАР: Энэхүү орчуулга нь Англи эхээс нь орчуулсан. Ямарваа нэг зөрүүтэй илэрхийлэл байх аваас Англи эхийг баримтлана. Энэ баримт бичгийн Англи хувилбар нь цорын ганц албан ёсны хувилбар болно.

Агуулга

| | |
|--|-----|
| Товчилсон үгс | ii |
| Гүйцэтгэх хураангуй..... | iii |
| I. УДИРТГАЛ..... | 1 |
| II. ТӨСӨЛ | 1 |
| III. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ХҮСЭЛТ | 2 |
| IV. ТУСГАЙ АСУУДЛУУД..... | 3 |
| V. УДИРДЛАГЫН ХАРИУ | 8 |
| VI. ДҮГНЭЛТ | 14 |

Хүснэгт

- Хүснэгт 1. Багануурын нүүрсний уурхайн хэрэглэгчид ба борлуулалт, кт (1,000 метр тонн)
Хүснэгт 2. Монголын төвийн бүсийн цахилгаан станцуудын нүүрсний эрэлтийн тооцоо
Хүснэгт 3. Монголын дулааны нүүрсний нийт эрэлтийн төлөв

Зураг

- Зураг 1. IBRD No. 43697

Хавсралт

- Хавсралт 1. Гомдол ба хариу: Анхны хүсэлт
Хавсралт 2. Гомдол ба хариу: Хоёрдугаар хүсэлт
Хавсралт 3. МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан техникийн судалгааг ил болгосон статус
Хавсралт 4. Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний нээлтийн үед зохион байгуулсан оролцогч талуудтай хэлэлцэх уулзалтууд

Товчилсон үгс

| | |
|--------|---|
| БЖ | Банкны журам |
| ДЦ | Дулаан цахилгаан |
| ХНҮ | Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| БОННҮ | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| ГДУММН | Газрын доорх усны менежмент, мэдээллийн нэгж |
| ОУСК | Олон Улсын Санхүүгийн Корпораци |
| ХХ | Хяналтын хороо |
| УННМТ | Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө |
| ОТХОББ | Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллага |
| МИНИС | Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл |
| Ст | Сая тонн |
| МВ | Мегаватт |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ҮАБ | Үйл ажиллагааны бодлого |
| СГЗ | Сав газрын захиргаа |
| СГЗӨ | Сав газрын зөвлөл |
| НБХ | Нийлэг байгалийн хий |
| АД | Ажлын даалгавар |
| ДЦС | Дулааны цахилгаан станц |
| ДБГ | Дэлхийн Банк Групп |

Гүйцэтгэх хураангуй

Төсөл

i. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (МИНИС эсхүл Төсөл) нь тэргүүлэх ач холбогдол бүхий уул уурхайтай холбоотой дэд бүтцийн хөрөнгө оруулалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, гүний усны нөөцийн удирдлагыг бэхжүүлэх гэх зэрэг дэмжлэг бүхий техникийн туслалцааг Монгол Улсын Засгийн газар (МУЗГ)-т үзүүлдэг болно. **Эдгээр судалгаанаас үүдэх ямар нэг хөрөнгө оруулалт, дэд бүтцийн барилгын ажил болон ашиглалтанд Төслөөс дэмжлэг үзүүлэхгүй болно.**

ii. **Төсөл нь санал болгож буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг судлах процесст зохион байгуулалт, системтэй арга барил болон ил тод байдлыг авчрах техникийн туслалцаа үзүүлэхийн дээр гүний усны менежментийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.** Эдгээр зорилгуудыг олон төрлийн судалгаа бэлтгэх, Монголын байгууллагуудын төсөл бэлтгэх болон хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах, хөрөнгө оруулалт ба санхүүгийн төлөвлөгөө боловсруулах болон хууль эрх зүйн орчинг хянаж, судлах замаар хангаж буй юм. 2014 онд батлагдсан төслийн нэмэлт санхүүжилт, бүтцийн өөрчлөлт нь Сав газрын захиргаад болон Сав газрын зөвлөлүүдийг Өмнө говийн бүс нутагт байгуулж, чадавхыг нь бэхжүүлэх гэх зэргээр гүний усны менежментийг бэхжүүлэх ажилд Төслийг чиглүүлж, түүний хамрах хүрээг өргөтгөхөд зориулагдсан юм. Төсөл нь ОУХА-ын эх үүсвэрээс 25 сая ам.доллартай тэнцэх зээл, Итгэлцлийн сангийн эх үүсвэрээс 4.05 сая ам.доллартай тэнцэх нэмэлт хөрөнгөөр санхүүжигдэж буй юм.

iii. **МИНИС-ийн дэмжиж буй судалгааны ихэнх нь боловсруулалтын шатандаа явагдаж байгаа.** Банкны бодлогын дагуу шаардлагатай гэвэл судалгааны төслүүдийг нийтэд ил болгож, эцэслэхээс нь өмнө хэлэлцүүлж буй болно. Төсөл нь 2019 оны 9-р сарын 30-нд хаагдах төлөвлөгөөтэй болно.

Хяналт шалгалт явуулах хүсэлт

iv. **Хяналтын хороо нь 2018 оны 5-р сарын 11-нд Төслийг хянаж, шалгах хоёр хүсэлт бүртгэсэн.** Тэдгээр Хүсэлтүүдийг Улаанбаатар хотын Багануур дүүргийн оршин суугчид болон Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгийн иргэдийн нэрийн өмнөөс Оюу Толгой хяналт ТББ болон орон нутгийн төрийн бус байгууллага хүлээлгэн өгсөн. Хүсэлт гаргагчид эхний Хүсэлтдээ эрүүл мэнд, орон нутгийн аюулгүй байдал, биеэ үнэлэх явдал болон аюулгүй байдал, агаарын бохирдолтой холбоотой нөлөөлөл, зөвлөлдөж хэлэлцэх, мэдээллийг ил болгох тал дээр дутагдалтай гэх зэрэг Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс үүдэн хор уршиг учирч болзошгүй гэж үзсэн. Хүсэлт гаргагчид хоёрдугаар Хүсэлтдээ уламжлалт газар болон усны нөөцийг ашиглах боломжгүй болох, байгаль орчны нөлөөлөл, зөвлөлдөж хэлэлцэх, мэдээллийг ил тод болгох тал дээр дутагдалтай гэх зэргээр усны менежментийн төлөвлөгөөнүүд болон гурван Сав газрын захиргаадад үзүүлж буй чадавхыг бэхжүүлэх ажлаас үүдэлтэй хор уршиг учирч буй гэж үзсэн.

Удирдлагын хариу

v. **Хүсэлт гаргагчдын тавьсан асуудал нь болзошгүй хор уршигт төвлөрсөн бөгөөд Банкнаас үзүүлж буй техникийн туслалцааны үр дүнд бий болохгүй юм. Банкнаас судалгаа хийх, чадавхыг бэхжүүлэх ажлыг дэмжиж буй болохоос уул уурхайн болон аливаа бусад дэд бүтцийг барьж байгуулах, ашиглах ажилд дэмжлэг үзүүлэхгүй юм.** Удирдлагын зүгээс ийм хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх шийдвэр гаргах юмуу амлалт өгөөгүйн дээр үүнтэй холбоотой аливаа нэг хүсэлт хүлээн аваагүй байгаа боловч Банкнаас үзүүлж буй техникийн зөвлөгөө нь тус Банкны бодлого, тэр дундаа түүнийг боловсруулах (үүнд нийтэд ил болгох, зөвлөлдөх ажил орно), дүгнэх болоод зөвлөмж гаргах процесстэй холбоотой бодлогыг мөрдүүлэх нь чухал гэдгийг Удирдлага хүлээн зөвшөөрч буй болно.

Удирдлага нь Төслийн хүрээнд санхүүжүүлж буй судалгаанууд МУЗГ ирээдүйд хийх хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргахад тус нэмэр болох обьектив, сайн мэдээллийн суурийг бүрдүүлэх нөхцөлөөр хангах зорилготой байна.

vi. **Банк нь Хүсэлт гаргагчдын анхны Хүсэлтдээ дурдсан цахилгаан станц, хоёрдугаар Хүсэлтдээ тусгасан уул уурхайн үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй болно.** Цахилгаан станц болоод уул уурхайн үйл ажиллагаа нь Банкны дэмжлэгтэй уг Төсөлтэй холбоогүй боловч Зээлдэгч нь эдгээр үйл ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцсэн бөгөөд хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Банкнаас санхүүжүүлсэн Хуримтлах нөлөөллийн үнэлгээ болон Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлж буй бөгөөд оролцогч талуудад асуудал сөхөх олон боломжоор хангаж буй болно.

vii. **Удирдлага нь Төсөлтэй холбоотойгоор Банк өөрийн бодлогыг зөрчсөн гэх Хүсэлт гаргагчдын байр суурьтай санал нэгдэхгүй байна. Эсрэгээрээ, Удирдлага нь Төслийн хүрээнд дэмжиж буй судалгаа, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа нь дэд бүтцийн тогтвортой хөгжлийг хөнгөвчилж, Хүсэлт гаргагчдын сөхөж буй олон санаа зовсон асуудлуудыг авч үзэж буй юм.** Төслийн хөгжүүлэлт, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, гүний усны менежментийн чиглэлээр Засгийн газрын чадавх хязгаарлагдмал тул МИНИС төсөл нь эдгээр чиглэлээр чадавхыг бэхжүүлэх чухал хувь нэмэр оруулж буй юм.

viii. **Удирдлага нь Төслийн хүрээнд дэмжлэг авч буй судалгаануудын талаарх Хүсэлт гаргагчдаас нэн ялангуяа тэдгээр судалгаануудын чанар, түүнд хамруулсан асуудлуудын хамрах хүрээ, тэдгээрийг нийтэд ил болгох, хэлэлцүүлэх асуудалтай холбогдуулан асуудлыг сөхөж буйд талархаж байна.** Оролцогч талууд нь хэлэлцүүлгийн үеэр эдгээр санаа зовниж буй асуудлуудаа илэрхийлж байсан бөгөөд Удирдлагын зүгээс тэдгээрийг шийдвэрлэх үүднээс Зээлдэгчтэй хамтран ажилласан. Удирдлага нь Төслийн хүрээнд дэмжлэг авсан холбогдох судалгааны талаар Хүсэлт гаргагчдын зүгээс тавьсан Төсөлтэй холбоотой асуудлыг судлахаар Зээлдэгчтэй ойр ажиллах болно.

ix. **Төслийн бусад асуудалтай холбоотой Хяналт, шалгалт явуулах өмнөх хүсэлтийн хариуд оролцогч талуудын оролцоог хангах Зээлдэгчийн чадавхыг сайжруулах зорилготой засаж, залруулах томоохон алхмуудыг авч хэрэгжүүлсэн болно.** Удирдлага нь Зээлдэгч энэхүү чадавхдаа түшиглэн Банкны санхүүжилттэй судалгаа болон төлөвлөгөөг Банкны бодлогын шаардлагын дагуу нийтэд ил болгож, хэлэлцүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

I. УДИРТГАЛ

1. Хяналтын хороо (Хороо) нь Хяналт, шалгалт явуулах хоёр хүсэлт хүлээн авсан ба тэдгээр нь Монгол Улстай холбоотой ХХ-ны Хүсэлтүүд RQ 18/02 болон 18/03 (Хүсэлтүүд) болно: Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА эсхүл Банк)-ийн санхүүжилттэй Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл – Нэмэлт санхүүжилт (P145439), (МИНИС эсхүл Төсөл). Анхны Хүсэлт (RQ 18/02) нь Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг, хоёрдугаар Хүсэлт (RQ18/03) нь Гүний усны удирдлагыг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг 3-т чиглэгдсэн болно. Хороо нь эдгээр Хүсэлтүүдийг нэгтгэн хянасан болно.

2. **Текстийн бүтэц.** Энэхүү баримт бичиг нь дараах хэсгүүдээс бүрдэнэ: Төслийн талаарх ерөнхий мэдээллийг агуулах Хэсэг II; Хүсэлтийн хураангуйг агуулах Хэсэг III; тусгай асуудлуудыг хамрах Хэсэг IV; Удирдлагаас өгөх Хүсэлтийн хариуг танилцуулах Хэсэг V; дүгнэлтийг агуулах Хэсэг VI. Хавсралт 1 болон 2-т Хүсэлт гаргагчдын гомдол болон түүнд Удирдлагаас өгсөн дэлгэрэнгүй хариултыг хүснэгт хэлбэрээр танилцуулсан болно. Хүснэгт 3 нь бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан техникийн судалгааг нийтэд ил болгосон статус, Хүснэгт 4-т усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөлтийн процессыг эхлүүлэх шатанд явуулсан оролцогч талуудтай хэлэлцэх уулзалтуудын жагсаалтыг тус тус харуулсан болно.

II. ТӨСӨЛ

3. Төслийн хүрээнд судалгаа явуулах замаар Зээлдэгчид¹ техникийн туслалцаа үзүүлж буй болно. Түүнчлэн уг төсөл нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бэлтгэх, гүний усны нөөцийн менежментийн дотоодын чадавхыг дэмждэг юм. Төсөл нь эдгээр судалгаанаас үүдэх аливаа хөрөнгө оруулалт болон аливаа дэд бүтцийг барих эсхүл ашиглахтай холбоотой санхүүжилт хийхгүй юм.

4. **Төслийн зорилтууд.** МИНИС төслийн хөгжлийн зорилтууд нь “*санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхай, эцсийн шатны боловсруулалтад үзүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэх дотоодын чадавхыг бэхжүүлэх*” болно. Эдгээр зорилтуудыг дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, Монгол байгууллагуудын төсөл бэлтгэж, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхийн тулд Төсөлтэй холбоотой техник, эдийн засгийн судалгаа (ТЭЗҮ), техникийн үнэлгээ, инженерийн дизайн, геотехникийн судалгаа, эдийн засаг болон санхүүгийн дүн шинжилгээ, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэх зэрэг олон төрлийн судалгааг боловсруулах замаар хангаж буй юм. 2014 онд батлагдсан бүтцийн өөрчлөлт болоод нэмэлт санхүүжилт нь гүний усны мониторингийн сүлжээг тавих, Газар доорх усны менежмент, мэдээллийн нэгж (ГДУММН), гурван Сав газрын захиргаад (СГЗ-д) болон гурван Сав газрын зөвлөлүүд (СГЗӨ-үүд)-ийг гэх зэрэг хэд хэдэн байгууллагыг байгуулж, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх болон техникийн судалгаа болон төлөвлөгөөг боловсруулах (Хүснэгт 3-ыг харна уу) замаар Өмнө говийн бүс нутгийн гүний усны удирдлагыг бэхжүүлэх Төслийн хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж буй юм.

5. **Төслийн үр өгөөж.** Төсөл нь Зээлдэгчийн чадавхыг нэмэгдүүлэх ба Засгийн газрын санал болгож буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг судлах явц, гүний усны менежментэд бүтэц зохион байгуулалт, системтэй аргачлал болон ил тод байдлыг бий болгох бөгөөд дата цуглуулалтыг давхар сайжруулах юм. Боловсруулагдаж буй судалгаанд Банкны

¹ Сангийн яам нь Зээлдэгчийг төлөөлдөг бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хяналт доор явагдах судалгааг дэмжих МИНИС төслийн зохицуулагч байгууллага юм.

бодлого, журмыг ашиглахдаа эдийн засаг, санхүү, байгаль орчин болон нийгмийн эрсдэлийг тодорхойлох, салбар болон төслийн түвшинд хоёрдогч хувилбаруудад (үүнд “төсөлгүйгээр” гэх хувилбар орсон болно) дүн шинжилгээ хийхэд онцгой анхаарч буй юм. МИНИС төслийн хүрээнд явуулах судалгааны цар хүрээ нь Банкны оролцоогүйгээр боловсруулж болох байснаас илүү цогц болж буй гэж үзэж буй юм. МИНИС нь Ангилал А-д хамаарах төсөл бөгөөд дараах хамгааллын бодлогуудыг үүнд хэрэглэсэн болно: Байгаль орчны үнэлгээ (ОР/ВР 4.01), Онгон байгаль (ОР/ВР 4.04), Биет соёлын өв (ОР/ВР 4.11), Албан нүүлгэн шилжүүлэлт (ОР/ВР 4.12), Далангийн аюулгүй байдал (ОР/ВР 4.37) болон Олон улсын усан замын төсөл (ОР/ВР 7.50).

6. **Төслийн статус.** Төсөл (P118109)-ийг Дэлхийн Банкны Захирлуудын Зөвлөлөөс ОУХА-ийн эх үүсвэрээс 25 сая ам.доллартай тэнцэх анхны хөрөнгөөр санхүүжүүлэхээр 2011 оны 5-р сарын 10-нд баталсан. Нэмэлт санхүүжилт ба бүтцийн өөрчлөлт (P145439)-ийг Итгэлцлийн сан (ИС)-гийн эх үүсвэрээс 4.05 сая ам.доллартэй тэнцэх нэмэлт хөрөнгөөр санхүүжүүлэхээр 2014 оны 3-р сарын 24-нд баталсан. 2018 оны 5-р сарын 31-ний байдлаар ОУХА-аас 17.324 сая ам.доллар, ИС-гаас 3.74 сая ам.доллар зарцуулаад байна. Төслийг хаах өдөр болох 2016 оны 9-р сарын 30-ны өдрийг эхлээд 2017 оны 9-р сарын 30, дараа нь 2019 оны 9-р сарын 30 болгож хоёр удаа сунгасан.

7. **Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд үнэлгээ хийж, судалж буй хөрөнгө оруулалтын саналууд.** Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд үнэлгээ хийж, судлахаар сонгогдсон 6 санал болгож буй хөрөнгө оруулалт байгаа ба үүнд: (i) Орхон говийн урсцын тохируулга хийх, усан сан барих төсөл; (ii) Сэлэнгэ гол дээрх Шүрэнгийн цахилгаан станцын төсөл; (iii) Дархан, Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн үйлдвэрийг цогцолборын хамт байгуулах төсөл; (iv) Багануурын нүүрс уурхайн өргөтгөлийн төсөл; (v) Өмнө говийн бүс нутгийн хөдөөгийн болон аж үйлдвэрийн усан хангамжийн төсөл (байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллөөс үүдэн Засгийн газраас цуцалсан); мөн (vi) нүүрснээс байгалийн хий (БХ) гаргаж авах үйлдвэр барих төсөл тус тус орсон. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн эцсийн бүтээгдэхүүн нь санал болгосон зургаан хөрөнгө оруулалт бүрт тэдгээрийн хэрэгжих боломжтой эсэхийг судалсан цогц ТЭЗҮ((iii), (iv), болон (vi)-д аль хэдийнээ боловсруулсан)-г олон талын нөлөөллийн үнэлгээтэй хамт боловсруулах болно.

8. **Бүрэлдэхүүн хэсэг 3 – Гүний усны удирдлагыг бэхжүүлэх** гэх энэхүү хэсэг нь техникийн болон институцийг бэхжүүлэх замаар Монголын өмнөд хэсэг дэхь гүний усны нөөцийг удирдах орон нутгийн эрх бүхий байгууллагын чадавхыг сайжруулахад чиглэгдсэн юм. Энэхүү бүрэлдэхүүн хэсэгт багтсан үйл ажиллагаанууд нь Монголын өмнөд хэсэг дэхь гүний усны менежментийг дэмжих, хурдацтай өсөж буй эрэлтийг хангах хэмжээний усан хангамжийг хөгжүүлэхэд зориулагдсан юм. Тодруулбал, Төсөл нь дараах үйл ажиллагааг дэмжиж буй юм: (i) ГДУММН-ийг байгуулах; (ii) СГЗ-үүдийг байгуулах; (iii) СГЗ-дыг байгуулах; (iv) Гүний усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (ГУННМТ)-нд зориулсан зөвлөх үйлчилгээ; (v) шинээр байгуулагдсан СГЗ-үүд болон СГЗ-дын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа; болон (vi) гүний усны үнэлгээ болон менежментийн судалгаа явуулах.

Ш. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ХҮСЭЛТ

9. Хүсэлт 18/02 (анхны Хүсэлт)-ийг өөрийн нэрийн ил болгохгүй байх хүсэлт тавьсан Улаанбаатар хотын Багануур дүүргийн 52 иргэний нэрийн өмнөөс Оюу Толгой Хяналт ТББ

болон орон нутгийн төрийн бус байгууллага (ТББ) ирүүлсэн. Хүсэлт гаргагчид нь Төслөөс санхүүжүүлж буй Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (ХНҮ)-нээс үүдэн эрүүл мэнд, охид болон эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, биеэ үнэлэх байдал болон агаарын бохирдлын нэмэгдэх, мэдээллийг нийтэд ил болгох болон хэлэлцүүлэх байдал дутагдалтай байгаа гэх зэрэг болзошгүй хор уршиг гарч байна гэж мэдэгдсэн.

10. Хүсэлт 18/03 (хоёрдугаар Хүсэлт)-ийг Оюу Толгой Хяналт ТББ болон өөрийн нэрийг нууцлах хүсэлт тавьсан Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 27 иргэн ирүүлсэн. Тэд Төслөөс санхүүжүүлж буй СГЗ-г байгуулах ажил болон усны менежментийн төлөвлөгөөнөөс үүдэн уламжлалт газар, усны нөөцийг ашиглах боломжгүй болгох, байгаль орчны нөлөөлөл үзүүлэх, мэдээллийг нийтэд ил болгох болон хэлэлцүүлэх тал дээр дутагдалтай байгаа гэх зэрэг болзошгүй хор уршиг учирч буй гэж үзсэн.

11. Эдгээр хоёр Хүсэлтүүд нь дээрх хэсэг 7 болон 8-д тодорхойлсон Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1 болон 3-ын хүрээнд санхүүжүүлж буй судалгааны талаар юм.

IV. ТУСГАЙ АСУУДЛУУД

Өмнө нь гаргасан Хяналт, шалгалт явуулах хүсэлт

12. Хүсэлт гаргагчид өмнө нь тухайн үед Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд санхүүжүүлэхээр санал болгосон байсан Шүрэнгийн цахилгаан станцын судалгаа болон Орхон говийн судалгаатай холбогдуулан 2015 онд Хүсэлт гаргаж байсан. Шүрэнгийн судалгаа нь Сэлэнгэ голын эхэд байрлах Шүрэн голтой нийлэх хэсэгт 160-245МВ-тын хүчин чадалтай усан цахилгаан станц барих боломжтой эсэхийг үнэлж, судлах зорилготой. Орхон говийн судалгаа нь Орхон голын урсцын тохируулга хийж, гадаргын ус хуримтлуулах далан бүхий усан сан барих төслийг үнэлж, судлах зорилготой.

13. Өмнөх Хүсэлтэд нөлөөллийн үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлэг болон хоёрдогч хувилбаруудын дүн шинжилгээ хангалтгүй гэж мэдэгдсэн. Түүнчлэн Төслийн хүрээнд Банкнаас олгох техникийн туслалцааны дараах биет барилгын ажлаас үүдэлтэй ноцтой байгаль орчны нөлөөлөл учирна гэж үзсэн байсан.

14. Уг Хүсэлтийн хариуд Удирдлагын зүгээс Хүсэлт гаргагчид нь санал болгож буй хөрөнгө оруулалтын барилгын ажил, ашиглалт болон/эсхүл бүтэлгүйтлээс үүдэж болох болзошгүй хор уршигт чиглэгдсэн асуудлуудыг дэвшүүлсэн болохоос Банкнаас санхүүжүүлж буй судалгаануудаас үүдэх хор уршигт чиглэгдсэн асуудлуудыг дэвшүүлээгүй байна гэж мэдэгдсэн. Удирдлага нь мөн мэдээлэл нийтэд ил болгох, хэлэлцүүлэг явуулах гэх зэрэг Төсөл удирдах нэгж (ТУН)-ийн олон нийтийн оролцоог хангах чадавхыг сайжруулах ажлыг эрчимтэй хийсэн бөгөөд Төслөөс санхүүжүүлж буй байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг сайжруулсан.

15. 2017 оны 7-р сард Хяналтын хорооноос Захирлуудын зөвлөлд хяналт, шалгалт явуулахгүй байх зөвлөмжийг агуулсан өөрийн тайланг гаргасан ба уг тайланд Монгол Улсын эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, эрчим хүчний олон хувилбаруудыг судлахад үзүүлж буй Банкны дэмжлэгийг онцолсон. Хороо нь олон нийтийн хэлэлцүүлэг болоод “нэн ялангуяа Хүсэлт гаргагчдад хариу өгөх, Орос-Монголын шинжлэх ухаанчдын хороог байгуулахад тууштай хандах чиглэлээр МИНИС-ийн ТУН-ийн чадавхыг дээшлүүлэх”-эд хүчин чармайлт гаргах гэх зэрэг Төсөлд томоохон тохируулга хийх шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улсын эрчим хүчний салбарт үзүүлж буй Дэлхийн Банк Группийн дэмжлэг

16. Монгол Улс нь дэлхий дээрх хүн амын хамгийн бага нягтшилтай улс юм. Эдийн засагт нь зэс, уран, нүүрс, төмрийн хүдэр болон алт гэх зэрэг байгалийн нөөцийн салбар давамгайлал нөлөө үзүүлдэг. Уул уурхайн салбар нь одоогоор Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний тавны нэгийг орчмыг эзэлж байна. Хэдийгээр байгалийн арвин их баялаг нь ирээдүйн эдийн засгийн өсөлт, хөгжлийн ихээхэн боломж олгож байгаа боловч уул уурхайн салбарыг Монголын урт хугацааны эдийн засгийн өсөлтийн тогтвортой эх үүсвэр болгох нь томоохон сорилт хэвээр байна. Засгийн газар нь уул уурхайн байгаль орчин болон нийгмийн салбар үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулахад анхаарсан оновчтой хууль, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай юм. Түүнчлэн эрчим хүч, тээвэр, ус болон аж үйлдвэрийн боловсруулах салбар сул хөгжсөн нь уул уурхайн хөгжлийг боомилж буй юм. Уул уурхайн хөгжлийг дэмжихэд шаардлагатай дэд бүтцийг цаг тухайд нь тогтвортой байдлаар төлөвлөх, бүтээн байгуулах болоод ашиглах нөхцөлөөр хангах нь Засгийн газарт тулгарч буй гол бэрхшээл юм. Өмнөговь аймагт байрлах Оюу Толгойн зэс, алтны уурхай болон Таван толгойн нүүрсний уурхай гэх мэт томоохон хэд хэдэн төсөл ихээхэн хэмжээний дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хөгжүүлэлтийн шатандаа явж байгаа (эсхүл цаашид хөгжүүлэх төлөвлөгөөтэй) нь эдгээр бэрхшээлүүдийг илүүтэй тулгамдсан асуудал болгож буй юм. Иймээс уул уурхайн үйл ажиллагааг тогтвортой байдлаар дэмжихэд шаардлагатай эрх зүйн зохицуулалт болоод дэд бүтцийг нэн даруй бий болгох хэрэгцээ шаардлага Монгол Улсад үүсээд байгаа юм.

17. Монгол Улсад эрдэс баялгийн хамаарлын эрсдэл байгаа нь түгээмэл мэдлэг юм. Эдгээр эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэх нь ДБГ-ээс үзүүлсэн хэдэн жилийн дэмжлэгийн цөм нь байсаар ирсэн. Уул уурхайн салбарыг гол тулгуур сэдвээ болгосон Завсрын стратеги 2009-2010 гэх ДБГ-ийн цогц стратеги нь Төслийг бэлтгэж, батлахад хүчин төгөлдөр үйлчилж байсан бөгөөд Монгол Улстай Түншлэх Стратеги 2013-2017 нь энэхүү стратегийг илүү гүнзгийрүүлэн тусгасан. Одоогийн Түншлэлийн стратегийн гурван тулгуурын эхнийх нь “Уул уурхайн эдийн засгаа тогтвортой бөгөөд ил тод удирдах Монголын чадавхыг сайжруулах” нь гэж томъёологдсон бөгөөд үүний хүрээнд ДБГ-ийн үйл ажиллагааны цогц багц зохион байгуулагддаг, үүнд: эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, уул уурхайн салбарын байгаль орчин болон нийгмийн менежментийг бэхжүүлэхэд² чиглэгдсэн техникийн туслалцаа; нэн шаардлагатай дэд бүтцийг сайжруулан төлөвлөх дэмжлэг;³ ОУСК болон ОТХОББ-ын уул уурхайн хөрөнгө оруулалтын “сайн туршлага”; Монгол Улсын байгууллагуудыг дорвитой ил тод, хариуцлагатай болгон бэхжүүлэх, сайжруулсан дата болон цахим-Засгаар дамжуулан иргэн төвтэй төрийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн техникийн туслалцаа;⁴ мөн төсөв, эдийн засаг болон мөнгөний менежментийн бодлогын хэрэгжилтийг бэхжүүлэх туслалцаа ту тус орно.⁵

18. Монгол Улсын эрчим хүчний салбар тус салбар дахь хурдацтай өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлтийг хангах, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, нүүрснээс ихээхэн хамааралтай байгаагаас үүдэх байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг бууруулахтай тус тус холбоотой хэд хэдэн, харилцан хамааралтай сорилтуудтай тулгарч байна. Уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн өсөлтөөс үүдэлтэйгээр 2020 он хүртэл цахилгааны эрэлт жилд 8-10 хувь өсөх төлөвтэй байна. Цахилгаан үйлдвэрлэл болон социализмын үед барьж хуучирсан, алдагдал ихтэй бөгөөд хүчин чадлынхаа дээд хязгаарт хүрч буй бүс нутгийн түгээх сүлжээнүүдийн аль алинд бэрхшээлүүд байгаа. Одоо байгаа эрчим хүчний сүлжээнүүдийн эмзэг байдлыг бууруулж, эрчимтэй нэмэгдэж буй эрэлтийг хангах хүчин чадлаа нэмэгдүүлэх томоохон хөрөнгө оруулалт хийхгүй бол Монгол Улс эрчим хүчний нийлүүлэлтийн хямралд яалт ч үгүй орохоор байна.

² Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны хөтөлбөр (МСИСТАП)

³ Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (МИНИС)

⁴ Монголын Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ЕПТ) хөтөлбөр, Ухаалаг засаг төсөл (СМАРТ), болон бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд явуулж буй засаглал, иргэдийн оролцоог сайжруулах нэмэлт үйл ажиллагаа

⁵ Олон салбарын техникийн туслалцааны хөтөлбөр (МСТАП) болон бусад явагдаж буй техникийн туслалцаа

19. Монгол Улс нь температур хасах 40°C хүрдэг хүнд хатуу өвөлтэй. Монгол Улсын дулаанаа бараг тэр чигээрээ нүүрсээр ажилладаг дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг станц (ДЦС), өрхийн хэмжээний зуух болон уурын зуухаас ихэвчлэн үйлдвэрлэдэг. Монгол Улсын нийт хүн амын бараг тэн хагас нь амьдардаг Улаанбаатар хот нь Багануурын нүүрсний уурхайгаас голлох нүүрсээ татдаг хэд хэдэн ДЦС-аас дулаан үйлдвэрлэх буюу дээрхтэй адилаар төвлөрсөн дулаанаар хангадаг.

20. Нүүрс нь Монгол Улсын эрчим хүчний зонхилох эх үүсвэр юм. Байгалийн хийгүй бөгөөд боловсруулсан газрын тосны бүхий л бүтээгдэхүүнийг гол төлөв Оросоос, бага зэргийг Хятад болон Өмнөд Солонгосоос импортолдог. Монгол Улс нь ус, салхи болон нарны сэргээгдэх эрчим хүч хөгжүүлэх өндөр боломжтой ба эдгээрээс суурь ачааллын урсгалыг хангахад усан цахилгаан нь хамгийн үр ашиг, хэмнэлттэй хувилбар юм. Хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор дэмжих тариф нэвтрүүлсэн 2007 оны Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар дамжуулан сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжиж байна. Сэргээгдэх эрчим хүчний салбар Монгол Улсад томоохон ирээдүйтэй. Гэсэн хэдий ч эрс тэс уур амьсгалтай тул ойрын хугацаанд дулаан болон цахилгааны салбарт нүүрс чухал байр суурь эзэлсэн хэвээр байна. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улс нь Парисын хэлэлцээрийн хүрээнд амласан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний зорилтот түвшин (ҮЗТ)-гээ хангахтай холбоотой томоохон бэрхшээлүүдтэй тулгарч байна.

21. МУЗГ-аас ахалсан ҮЗТ-ний түншлэлд оролцох, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн дэмжих, дулааны салбарын үр ашгийг нэмэгдүүлэхэд ДБГ-ийн хэмжээнд хувь нэмэр оруулах замаар Банкны зүгээс Монголы Улсын Засгийн газар (МУЗГ)-т өөрийн ҮЗТ-нийг хангах, тогтвортой эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. ДБГ нь МУЗГ-ын 100,000 нарны гэр хөтөлбөрт дэмжлэг үзүүлсэн бөгөөд одоогийн байдлаар сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх үүднээс баруун аймгуудад 10МВ-ын нарны цахилгаан станц барьж, шугамын холболт, тарифын асуудлыг хянан үзэж байгаа бөгөөд Улаанбаатар хотын гадна байрлах салхины станцад хөрөнгө оруулсан юм. Түүнчлэн МИНИС төсөл нь хоёр боломжит усан цахилгааны хөрөнгө оруулалттай холбоотой судалгааг дэмжиж байна. МУЗГ нь сэргээгдэх эрчим хүчний стратегийн чиглэлээр дэмжлэг авах хүсэлт гаргасан ба Банкны зүгээс энэхүү хүсэлтийн дагуу яриа хэлэлцээр хийхэд бэлэн байна.

22. Эрчим хүч, уул уурхай болон ус хоорондоо чухал уялдаа холбоотой тул МИНИС төсөлд дээр тодорхойлсон Өмнө говь аймгийн гүний усны удирдлагын бүрэлдэхүүн хэсгийг оруулсан юм.

Багануурын нүүрсний уурхай ба санал болгож буй уурхайн өргөтгөл

23. Багануурын нүүрсний уурхай нь 1978 онд анх байгуулагдсан бөгөөд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн тийш 130км-т байрладаг (доорх Зураг 1-ийг харна уу). Уг уурхай нь үндэсний хэмжээнд нүүрс олборлолтын 55 хувийг эзэлдэг, нүүрсээ төвийн бүсийн хэрэглэгчид болон Улаанбаатар хотын эрчим хүчний гол эх үүсвэр болох гурван ДЦС-д нийлүүлдэг. Нүүрс олборлолтын гарц 1992 он хүртэл нэмэгдэж, тухайн жил хүчин чадал нь жилд 4 сая тонн болсон. 1990-ээд оны Монголын эдийн засгийн хямрал нь уурхайн үйлдвэрлэлийг бууруулсан. Японы Засгийн газраас 1993 онд боловсруулж өгсөн нүүрсний салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, Банкнаас 1994 онд тус бүс нутагт хийсэн нүүрсний судалгааны дараа МУЗГ-аас Багануурын уурхайг өргөтгөх шийдвэр гаргасан. 1996-аас 2002 онд уурхайн олборлолт нэмэгдэж, уул уурхайн төхөөрөмжийг шинэчилж, хүний нөөцийг менежментийг сайжруулж, урт хугацааны нүүрсний олборлолтоос үүдэх байгаль орчны тогтвортой байдлыг хангах, байгаль орчны нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх алхмуудыг хэрэгжүүлсэн.

⁶ Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлд Банкнаас дэмжсэн үйл ажиллагааны хуваарийг Хавсралт 1-ээс харна уу.


Mongolia

Одоогийн олборлолтын түвшин 3.5-3.8 сая тонн/жил (ст/ж)-нд хэлбэлзэж байна. Орлогын түвшин 2016 онд \$41.4 сая ам.доллар, 2017 онд 66.5 сая ам.доллар тус тус байсан. Одоогийн орлогын томоохон хэсэг арилжааны борлуулалтаас бүрддэг. Уг уурхай нь нүүрсээ нийлүүлдэг олон харилцагчидтай бөгөөд ихэнх нь цахилгаан станцууд юм.

23. Банкны зүгээс Төслийн хүрээнд одоогийн олборлолтыг 6.2-6.5 ст/жил-ээр нэмэгдүүлж, 10 ст/жил-д хүргэх уурхайн өргөтгөлийн төслийг үнэлэх ТЭЗҮ боловсруулах ажлыг дэмжсэн. Аливаа нэг өргөтгөл хийх нь Монгол даяарх олон эрчим хүчний станцуудыг дэмжих бөгөөд 2073 он хүртэлх улсын хэмжээнд өсөн нэмэгдэх нүүрсний хэрэгцээг хангаж болох юм. Уурхайн өргөтгөлөөс үүдэх болзошгүй нөлөөллийг үнэлэх ажлын хүрээн Банкны зүгээс Хэрлэн голын сав газар, нүүрсний хэрэглээ бүхий гол газрууд, уурхайн олборлолтын үйл ажиллагаа орчим дахь үйл ажиллагаанд үзүүлэх уурхайн өргөтгөлийн хуримтлагдах нөлөөллийг үнэлэх зорилготой ХНҮ-г санхүүжүүлж буй юм.

24. Уг ХНҮ нь олон нийтээр нэмж хэлэлцүүлсний дараа 2018 оны эцэст эцэслэн боловсруулагдах төлөвлөгөөтэй байна⁶. Ажлын даалгавар (АД)-тай холбоотой хэлэлцүүлэг 2014 онд явагдсан. ХНҮ-ний өмнөх төсөл дээр 2015 оны 9-р сар болон 2016 оны 4-р сард хэлэлцүүлэг явуулсан. Хамгийн сүүлд боловсруулсан ХНҮ-ний төслийг хянан үзэж, Банкны зүгээс техникийн чанар хангасан гэж үзсэний дараа хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна. Хэлэлцүүлгийг Багануурын уурхайн өргөтгөлийн нөлөөлөлд өртөх магадлалтай орон нутгийн иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд, иргэдийг оролцуулахад тохиромжтой газруудад зохион байгуулна. Эцэслэн боловсруулсны дараа, ХНҮ нь ТЭЗҮ-г шинэчлэн найруулж, өөрчлөлт оруулах болоод Монголын хуулийн дагуу 2018 оны эцэс гэхэд Зээлдэгчийн зүгээс БОННУ-нд оруулахаар төлөвлөсөн өөрчлөлтөд шаардлагатай мэдээллээр хангах юм. 2017 оны 11-р сарын 21-нд Банкны Удирдлагын зүгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд уурхайн өргөтгөлийн хөрөнгө оруулалт нь зөвхөн ХНҮ-г эцэслэж, холбогдох хэлэлцүүлэг явуулсны дараа урагшлах боломжтойг онцолсон захиа явуулсан. Үүнтэй төстэй захиаг Эрчим хүчний яаманд 2018 оны 6-р сарын 4-нд явуулсан. МУЗГ-аас уурхайг өргөтгөх ажил эхлээгүй байгааг баталгаажуулсан.

Газрын зураг 1. Багануурын нүүрсний уурхай болон түүний харилцагчдын хамаарал



Багануурын уурхайн өргөтгөл болон түүний ойролцоох дулааны цахилгаан станцын хамаарал

26. Багануурын нүүрсний уурхай нь олон этгээдэд нүүрс нийлүүлдэг (Хүснэгт 1). Боломжит харилцагчдын нэг нь энэхүү уурхайн ойролцоо барихаар төлөвлөж буй Багануурын нүүрсээр галлах дулааны станц (ДС).

Хүснэгт 1 Багануурын нүүрсний уурхайн харилцагчид ба борлуулалт, кт (1,000 метр тонн) (эх сурвалж: ТЭЗҮ)

| | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|-----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| ДЦС-4 | 1,331.5 | 1,382.0 | 1,451.8 | 1,521.0 | 1,478.3 | 1,611.1 | 1,669.8 |
| ДЦС-3 | 892.7 | 1,028.9 | 944.3 | 1,102.6 | 1,077.2 | 1,106.3 | 1,166.7 |
| ДЦС-2 | 178.2 | 184.9 | 174.3 | 196.3 | 195.1 | 196.6 | 185.8 |
| Дарханы ДЦС | 112.0 | 105.3 | 133.6 | 207.8 | 158.5 | 125.2 | 125.2 |
| Эрдэнэтийн ДЦС | 60.1 | 9.1 | 53.7 | 112.7 | 52.6 | 39.6 | 16.4 |
| Багануурын ДЦС* | 55.8 | 60.1 | 59.4 | 58.3 | 58.2 | 65.8 | 61.4 |
| Бусад | 197.3 | 215.7 | 201.0 | 209.7 | 243.9 | 401.4 | 599.2 |
| Нийт | 2,827.6 | 2,986.0 | 3,018.1 | 3,408.4 | 3,263.8 | 3,546.0 | 3,824.5 |

* Багануурын сайтын уурхай болон ойр орчмын суурьшлын бүсэд эрчим хүч, дулаанаар хангах одоогийн хүчин чадал. Энэ нь баригдаагүй байгаа 700МВ-ын Багануурын ДЦС-аас тусдаа болно

27. Хөрөнгө оруулалтын газар болон ДЦС-ын оператор Багануур Поверын хооронд байгуулсан концессын гэрээний орчуулгыг Монголын Засгийн газрын хуудсаас авч үзэх боломжтой.⁷

Энэхүү орчуулгаас үзвэл, уг гэрээнд Багануурын нүүрсний уурхайгаас ДЦС-ад нүүрс нийлүүлнэ гэж заасан бөгөөд Засгийн газрын зүгээс ДЦС-ыг нүүрсээр тэргүүн ээлжид хангах, ДЦС-ыг баригдаж дуусахад Багануурын уурхайг өргөтгөсөн байх үүрэг хүлээсэн байна. Хэрэв Засгийн газар нь ДЦС-ын Багануурын уурхайгаас шаардах нүүрсийг нийлүүлж чадахгүй тохиолдолд бусад ойролцоох нүүрсний уурхайнуудаас зохих хэмжээ, чанартай нүүрсээр нийлүүлэх үүрэгтэй юм. ДЦС-ад шаардагдах нүүрсний хэмжээ нь уурхайн өргөтгөлөөс үүдэх төлөвлөсөн нүүрсний олборлолтын нэмэгдлийн ойролцоогоор хагастай, мөн хэрэв Багануурын уурхайн өргөтгөлийг бүрэн хэрэгжүүлэхгүй байх тохиолдолд нийт олборлолтынх нь гуравны нэгтэй тус тус тэнцэх юм. ДЦС нь бүрэн өргөтгөсөн уурхайн дор хаяж зургаан шинэ харилцагчийн нэг байх юм (Хүснэгт 2-ыг харна уу). ДЦС-ын нүүрсний хэрэгцээ нь ашиглалтанд орсон эхний гурван жилдээ 3 ст/жил байхаар байна (Хүснэгт

28. 3-ыг харна уу).

Хүснэгт 2. Монголын төвийн бүс дэхь станцуудын нүүрсний эрэлтийн тооцоо (Эх сурвалж: ТЭЗҮ)

| | | | |
|----------------|----------------------|-----------------|----------------|
| Өргөтгөл | ДЦС 4 өргөтгөл | /100МВ/ | |
| | ДЦС 4 өргөтгөл | /50МВ/ | |
| | Дарханы ДЦС өргөтгөл | /50МВ/ | |
| | <i>Нийт</i> | <i>/200МВ/</i> | <i>0.75 Мт</i> |
| Ирээдүйн төсөл | Багануурын ДЦС | /700МВ/ | 3.00 Мт |
| | ДЦС5 | /450МВ/ | 2.60 Мт |
| | Амгалангийн ДЦС | /348МВ/ | 0.35 Мт |
| | <i>Нийт</i> | <i>/1498МВ/</i> | <i>5.95 Мт</i> |

7 <http://nda.gov.mn/backend/f/rcnv1crjX5.pdf> -д нийтэд ил болгосон (2018 оны 5-р сарын байдлаар).

Хүснэгт 3. Монгол Улсын хэмжээнд дулааны нүүрсний эрэлтийн төлөв
(Эх сурвалж: ТЭЗҮ)⁸

| | | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|-------------|---------------------------------|-------------|-------------|-------------|--------------|--------------|--------------|
| 1 | Үндсэн хэрэглэгчид | 5.70 | 5.70 | 5.70 | 5.70 | 5.70 | 5.70 |
| 2 | Төвийн бүсийн өргөтгөл | 0.75 | 0.75 | 0.75 | 0.75 | 0.75 | 0.75 |
| 3 | Шинэ хэрэглэгч (ДЦС-5) | | | 2.60 | 2.60 | 2.60 | 2.60 |
| 4 | Шинэ хэрэглэгч (Багануурын ДЦС) | | | | 3 | 3 | 3 |
| 5 | Нүүрснээс шингэн MCS | | | | | 3 | 4 |
| 6 | Нүүрснээс хий Хятад | | | | | | 20 |
| Нийт | | 6.45 | 6.45 | 9.05 | 12.05 | 15.05 | 36.05 |

29. ТЭЗҮ болон бусад судалгаанд зориулж техникийн туслалцаа үзүүлж буй нөхцөлд Банкнаас санхүүжүүлж буй “төсөл” нь тэрхүү техникийн туслалцаа үзүүлж буй бөгөөд энэ нь биет үйл ажиллагаа эсхүл дэд бүтцэд хөрөнгө оруулахтай холбоотой ирээдүйн шийдвэрээс хамааралгүйгээр явагдаж буй юм. МИНИС төслийн хүрээнд явагдаж бус техникийн туслалцаа нь Багануурын уурхайн өргөтгөлийг хийх боломжтой эсэхийг үнэлэх, үнэлгээндээ уурхайн нөлөөллийн бүс дэхь нөлөөлөл болон эрсдэлүүдийг харгалзан үзэх гэх зэрэг зорилготой юм. ДС нь Төслийн хүрээнд судалж байгаа санал болгосон хөрөнгө оруулалтын нэг биш боловч газар зүйн хувьд ойр мөн нүүрс худалдан авна гэдэг утгаараа ХНҮ-нд хамрагдаж буй болно. Уг үнэлгээ нь уурхайн нөлөөллийн бүс дэхь уурхайн өргөтгөлийн хуримтлагдах нөлөөллийг үнэлэх зорилготой юм.

30. Банк нь ДЦС-тай холбоотой ямар нэг судалгаа эсвэл бусад төрлийн үйл ажиллагаа санхүүжүүлээгүй болно. Багануурын ДЦС-ыг барилгын ажил 2017 онд эхэлж, барилгын ажилчдын байр гэх зэрэг бэлтгэл ажил голчлон хийгдсэн боловч иргэний нийгмийн байгууллагуудын хүчтэй эсэргүүцэл, улсын хэмжээний эрчим хүчний одоогийн хэрэгцээ болон Монгол улсын төвийн бүсийн эрчим хүчний системийн шингээх чадварын хязгаарлагдмал байдалтай харьцуулахад ийм том станц барих нь зохистой эсэх асуултуудаас үүдэн зогссон байгаа болно.

⁸ Энэхүү хүснэгтийг 2015 онд боловсруулсан учраас шинэ байгууламж болон өргөтгөл хойшилсон, эцсийн шийдвэр гараагүй тул хуучирсан.

V. УДИРДЛАГЫН ХАРИУ

31. Хүсэлт гаргагчдын гомдол, түүнд Удирдлагын зүгээс өгсөн дэлгэрэнгүй хариултуудыг Хавсралт1 (анхны Хүсэлт) болон Хавсралт 2 (хоёрдугаар Хүсэлт)-оос тус тус харна уу.

32. *Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд нь Банкны зүгээс МИНИС төслийн хүрээнд санхүүжүүлж буй судалгаа эсхүл чадавхыг бэхжүүлэх ажлаас үүдэх хор уршиг биш, харин зөвхөн санал болгож буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын барилгын ажил, ашиглалт болон/эсхүл бүтэлгүйтлээс үүдэх болзошгүй хор уршигт төвлөрсөн байна.* Удирдлагын зүгээс тус Банк нь МИНИС төслийн хүрээнд судалж буй санал болгосон ямарваа нэг хөрөнгө оруулалтын барилгын ажлын санхүүжүүлэхэд оролцоогүйн дээр Удирдлагын түвшинд тэдгээрийг санхүүжүүлэх шийдвэр эсхүл амлалт өгөөгүй, санхүүжилтийн хүсэлт хүлээн аваагүйг онцолж байна. МУЗГ-т мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай объектив мэдээллийн суурийг тавих зорилготойгоор төслийн зүгээс санхүүжүүлэх хараат бус зөвлөхийн хийх судалгаанууд болоод тэдгээр хөрөнгө оруулалтыг явуулах, уг судалгаануудын зөвлөмжийг хүлээн авах эсхүл хэрэгжүүлэх эсэх талаарх МУЗГ-ын шийдвэрийг хооронд нь нарийн ялгаж, салган ойлгох шаардлагатай.

33. *Удирдлага нь тус Банкнаас олгож буй техникийн зөвлөмжийг холбогдох бүхий л Банкны бодлоготой нийцүүлэх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч буй бөгөөд үүнд түүний бэлтгэл (мэдээллийг нийтэд ил болгох болоод хэлэлцүүлэх орно), дүгнэлт болон зөвлөмжийг гаргахад мөрдсөн процесс мөн хамаарна.* Удирдлагын зүгээс Төслийн хүрээнд дэмжлэг үзүүлж буй судалгаанууд нь МУЗГ санал болгож буй хөрөнгө оруулалтыг авч үзэн, шийдвэр гаргахад тус болох объектив, оновчтой мэдээллийг бүрдүүлэх нөхцөлөөр хангахад тууштай анхаарсан хэвээр байна.

34. *Банкны зүгээс Хүсэлт гаргагчдын анхны Хүсэлтдээ дурдсан цахилгаан станц, хоёрдугаар Хүсэлтдээ дурдсан уул уурхайн үйл ажиллагааг санхүүжүүлээгүй.* Цахилгаан станц болон уул уурхайн үйл ажиллагаа нь Банкны санхүүжилттэй төсөлтэй холбоогүй боловч Зээлдэгчийн зүгээс эдгээр үйл ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцэж байсан бөгөөд хэлэлцсэн хэвээр байх болно. Банкнаас санхүүжүүлж буй Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болон Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлж байгаа бөгөөд оролцогч талуудад асуудал дэвшүүлэх олон сувгаар хангаж байгаа. Удирдлага нь МИНИС төслийн хүрээнд дэмжлэг үзүүлж буй судалгаануудыг нийтэд ил болгох, хэлэлцүүлэхтэй холбоотойгоор Банкны хамгааллын бодлогын дагуу заавал авч хэрэгжүүлэх холбогдох шаардлагуудыг хангаж байгааг онцолж байна.

35. *МИНИС төслийн санхүүжилттэй Багануурын нүүрсний уурхайн ХНУ нь одоо ч боловсруулалтын шатандаа явж байгаа бөгөөд уурхайн өргөтгөлийн барилгын ажил эхлээгүй байгаа болно.* Хүсэлт гаргагчид болон бусад оролцогч талууд ХНУ-ний ажлын даалгавар, тус үнэлгээний төсөл гэх зэрэгтэй холбоотой өөрсдийн санал бодлыг илэрхийлэх боломжуудаар хангагдаж ирсэн. Оролцогч талууд нь ХНУ-г эцэслэх, 2013 онд хийгдсэн Багануурын уурхайн өргөтгөл, түүнтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах БОННУ-г шинэчлэх үед санаа зовж буй асуудлуудаа дэвшүүлэх бусад боломжуудаар хангагдана.

36. *Банкны зүгээс МИНИС төслийн судалгаанд зориулан боловсруулсан мэдээллийг нийтэд ил болгох, олон нийтээр хэлэлцүүлэх удирдамжийн дагуу Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд санхүүжүүлж буй УННМТ-г орон нутгийн ТББ гэх зэрэг бусад оролцогч талуудаар хэлэлцүүлж, зөвлөлдөх шаардлагатай болохыг Зээлдэгчид мэдэгдсэн ба Засгийн газар энэхүү зорилгоор олон нийтээр хэлэлцүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулсан болно.* Удирдлага нь одоогоор уг хэлэлцүүлэх төлөвлөгөөнд санал өгч байгаа бөгөөд тэдгээрт Банкны бодлогын шаардлагыг тусгуулахаар Зээлдэгчтэй хамтран ажиллаж байна. УННМТ-ний ажил одоо явагдаж байгаа бөгөөд 2018 оны эцсээр тэдгээрийг эцэслэж, хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна.

37. *Удирдлага нь МИНИС төслөөс санхүүжүүлж буй судалгаа, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ нь дэд бүтцийн тогтвортой хөгжлийг дэмжиж, Монгол Улс дахь чадавхтай холбоотой асуудлуудыг шийдэхэд тус болно гэж итгэж буй юм.* Удирдлагын үзэж буйгаар Төслөөс санхүүжүүлж буй техникийн туслалцаа нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хөгжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйд МУЗГ шийдвэр гаргахад шаардлагатай оновчтой бөгөөд ил тод суурийг бий болгож байгаа бөгөөд МИНИС төслийн санхүүжүүлж буй судалгаанууд нь

чадавх хязгаарлагдмал тул МИНИС төсөл нь эдгээр чиглэлээр чадавхыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж буй юм.

38. *Хүсэлтүүдэд дэвшүүлсэн тусгай асуудлууд.* Удирдлага нь энэхүү хэсгийн үлдэгдэл хэсэгт тусгай асуудлуудыг авч үзсэн болно.

Санал болгож буй Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлтэй холбоотой судалгаанууд

39. *Төслөөс Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-г санхүүжүүлсэн. ТЭЗҮ-г 2015-2016 оны хооронд явуулсан ба үлдсэн байгаа ихээхэн хэмжээний нүүрсний нөөц, нүүрсний эрэлтийн өсөлтийн прогнозод тулгуурлан тоног төхөөрөмжийн бааз, шат дамжлагаа өргөтгөж, шинэ олборлолтын арга, технологийг нэвтрүүлэх замаар 40 жилийн настай Багануурын уурхайн нүүрсний олборлолтыг өргөтгөх эдийн засгийн хувилбаруудыг тодорхойлох зорилготой байсан.* ТЭЗҮ нь үнэлгээг явуулах үеийн олборлолтын хүчин чадал болох 3.5-3.9 ст/жил-ийг 10 ст/жил болгон нэмэгдүүлж, нэгж үйл ажиллагааны зардлыг хасах байдлаар зардлаа нөхөх боломжтой гэж дүгнэсэн. Ингэж өргөтгөх нь Багануурын уурхайгаас нүүрс худалдан авах олон тооны шинэ харилцагч бий болгоно гэж хүлээлттэй байгаа юм.

40. *Удирдлага нь уг ТЭЗҮ-г нийтэд ил болгож, хэлэлцүүлсэн байдал болон түүний дүгнэлт, зөвлөмж нь тус Банкны бодлогын холбогдох шаардлагуудыг хангасан гэж үзэж байна.* ОР/ВР 4.01-т заасны дагуу Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллүүдтэй холбоотой мэдээлэл, баримт бичгүүдийг нийтэд ил болгож, хэлэлцүүлж байгаа. Нийтэд ил болгох шаардлага нь МИНИС төслөөс санхүүжүүлсэн ТЭЗҮ-д хамаарахгүй. Банкны зүгээс МИНИС төслөөс санхүүжүүлсэн судалгаатай холбоотой аль болох их мэдээллийг нийтэд ил болгох тал дээр ТУН-ийг тууштай дэмжиж ирсэн боловч Зээлдэгчийн зүгээс нууцад тооцох мэдээлэл ТЭЗҮ-д орсон болно. Тиймээс Удирдлага нь Банкны Мэдээллийн хүртээмжийн бодлогын хэсэг 2(g)-д “гишүүн орон болон гуравдагч этгээдээс олгосон нууцлалын зэрэгтэй мэдээлэл” гэж заасны дагуу уг ТЭЗҮ-г нууцлалын зэрэгтэй баримт бичиг гэж үзэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

41. *Төслөөс санхүүжүүлж буй ХНҮ нь одоогийн Багануурын уурхай, түүний боломжит өргөтгөл, ДЦС-ын барилга ашиглалт болон ХНҮ-ний газар зүй, сэдвийн хамрах хүрэн дэхь бусад “дарамт үзүүлэгч” хүчин зүйлсийг судалсан.* Түүнчлэн, ХНҮ нь 2013 оны уурхайн өргөтгөлийн БОННҮ-г Зээлдэгчийн зүгээс шинэчилж, өөрчлөхөд ач холбогдолтой мэдээллээр хангах юм. ХНҮ болон холбогдох хэлэлцүүлэг 2018 оны эцэст эцэслэх төлөвлөгөөтэй байна. Эцэслэн боловсруулсны дараа, ХНҮ нь ТЭЗҮ-г шинэчлэн найруулж, өөрчлөлт оруулах болоод Монголын хуулийн дагуу 2018 оны эцэс гэхэд Зээлдэгчийн зүгээс БОННҮ-нд оруулахаар төлөвлөсөн өөрчлөлтөд шаардлагатай мэдээллээр хангах юм. *ХНҮ-ний АД-ын төслийг 2014 онд хэлэлцүүлсэн. ХНҮ-ний эхний төслийг 2015 онд нийтэд ил болгож, хэлэлцүүлсэн. Удирдлагын зүгээс ХНҮ-ний төслийн чанар хангалтгүй гэж үзсэн.* Удирдлага нь ХНҮ-ний эхний төслийг боловсруулсан анхны зөвлөхийн гэрээг цуцлах зөвлөмжийг Зээлдэгчид өгсөн. Түүнчлэн Удирдлага ХНҮ-ний эхний төсөл дээр хийсэн хэлэлцүүлэг нь олон нийтээр хэлэлцүүлэх сайн туршлагыг хангаагүй гэж үзэж, Зээлдэгчийг хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах шаардлага тавьсан ба уг хэлэлцүүлэг нь 2016 оны 4-р сард явагдсан. Хоёр дахь хэлэлцүүлэгт Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар, хорооны дарга болоод ахлах ажилтнууд, ЖДҮ-ийн газар, орон нутгийн ТББ-ууд, Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газар, Багануур Уурхай ХХК болон бусад орон нутгийн хувийн хэвшлийн төлөөлөгчид, нутгийн иргэд болон ИНБ-ууд гэх зэрэг нийт 81 хүн оролцсон. Эдгээр хэлэлцүүлгүүдийн талаарх дэлгэрэнгүйг МИНИС төслийн вэб хуудаснаас авах боломжтой.⁹

42. *Олон улсын зөвлөх авч ажиллуулах, зөвлөхийн ажлын хамрах хүрээг тодорхойлох ажлыг хөнгөвчлөх зорилгоор ХНҮ-г шинэчлэн боловсруулахад зориулсан шинэ АД-т оролцогчдын дэвшүүлсэн энэхүү хэлэлцүүлгийн саналыг тусгасан болно.* Банк нь Төслийн вэб хуудсан дээр АД-ыг нийтэд ил болгохыг Зээлдэгчид зөвлөх болно. Туршлагатай олон улсын зөвлөх 2016 оноос хойш ХНҮ-г шинэчлэх ажил дээр ажиллаж байна.

⁹ <http://minis.mn/en/p/baganuur-cia>

43. *ХНҮ-ний төслийг шинэчлэн боловсруулахаар Зээлдэгчийн авч ажиллуулж буй зөвлөх нь хэлэлцүүлгийн үеэр оролцогч талуудаас тавьсан санаа зовинож буй асуудлууд болоод тэдний*

саналыг авч үзэн судалгааны одоо байгаа хамрах хүрээг хянаж, шинэчлэн боловсруулах тодорхой чиглэл авсан болно. Төслийн баг нь 2016 оны сүүлээс хойш ХНУ-ний хэд хэдэн төслийг хянан үзэж, Зээлдэгчид саналаа хүргүүлсэн. Зөвлөх нь одоогийн байдлаар 2018 оны 4-р сард хамгийн сүүлийн удаа авсан санал дээр үндэслэн ХНУ-г шинэчлэн боловсруулж байна. Банк нь ХНУ-г хангалттай гэж үзэх хүртлээ хянах процессийг үргэлжлүүлнэ. Одоогийн шинэчлэн боловсруулалт эцэслэгдэн дууссаны дараа ХНУ-г дахин нийтэд ил болгож, хэлэлцүүлнэ. Удирдлага нь ХНУ-г 2018 оны эцэст эцэслэгдэнэ гэж үзэж байна.

44. *Уурхайтай ойр байрлалтай, нүүрс худалдан авах тохиролцоо хийсэн гэж үзэн Банкнаас санхүүжүүлж буй ХНУ-нд ДЦС-ыг хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний нэг хэсэг болгон авч үзэх болсныг онцолж байна.* Тиймээс Удирдлага нь Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуудлуудыг ХНУ-нд хамруулсан үзэж байгаа гэдэгт итгэж байна. Удирдлага нь эцсийн ХНУ нь ашигласан үнэлгээний аргачлал, нийтэд ил болгох, хэлэлцүүлэх, МУЗГ-ын зүгээс авч үзэх ирээдүйн аливаа хөрөнгө оруулалтын талаарх зөвлөмжийн хувьд Банкны бодлогын шаардлагуудыг хангасан байх нөхцөлөөр хангуулах тал дээр Зээлдэгчтэй хамтран ажиллана. Банк нь 2014 онд ДЦС-ын БОННУ-г бэлтгэх эсхүл хянах ажил болоод түүнд орсон аливаа өөрчлөлтөд оролцоогүй болно. Засгийн газар нь эцсийн ХНУ-ний үр дүнг ашиглан 2013 оны уурхайн өргөтгөлийн БОННУ-г шинэчлэн боловсруулах ба үүнийг Монгол Улсын хуулийн дагуу 2018 онд хийх ёстой юм. ХНУ-г эцэслэсний дараа МУЗГ нь ДЦС-ыг төслийг хөгжүүлэхтэй холбогдуулан шинэ мэдээлэл харгалзан үзэх боломжтой болох юм.

45. *Уурхайг өргөтгөн нэмж олборлосон нүүрсийг боловсруулах, тээвэрлэх, шатаах эсхүл хий гаргахтай холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдийг ХНУ-нд үнэлнэ.* Үүний хүрээнд нүүрс болон түүнийг хүрээлсэн чулуун массад агуулагдах цацраг идэвхт элементүүдтэй холбоотой эрсдэлийг үнэлнэ. 2016 оны ТЭЗҮ-д нь 2012 болон 2013 онд Багануурын нүүрсэнд хийсэн цацраг идэвхийн үнэлгээг тусгасан ба Багануурын уурхайд олборлодог нүүрсний масс дахь цацрагийн хэмжээ энгийн болон бага түвшинтэй гарсан. Энэхүү үнэлгээнд цацрагийн өндөр түвшинтэй цөөн тооны нууц бүсийг тодорхойлсон ба тэдгээр нь ихэвчлэн гадаргатай ойрхон исэлдлийн бүсүүд эсхүл нүүрний цууралтын түвшин өндөртэй газруудаас үүдэлтэй байсан. Тэдгээр бүсүүдийг тусгаарлахаар тодорхойлсон ба тэдгээр газраас олборлосон нүүрсийг цэвэршүүлж, зохих горимын дагуу хадгалдаг. Эдгээр асуудлуудыг шинэчлэн боловсруулах ХНУ-нд авч үзнэ.

46. *Банкны дэмжлэгтэйгээр МИНИС-ийн ТУН нь 2015 оны Хяналт, шалгалт явуулах хүсэлтээс хойш оролцогч талуудын оролцоог хангах чадавхаа эрс сайжруулж чадсан.* Хяналтын хорооноос тухайн Хүсэлтэд өгсөн өөрийн Эцсийн тайлан, зөвлөмжид илт хүлээн зөвшөөрсөн. Эдгээр хүчин чармайлтын талаарх дэлгэрэнгүйг Хяналтын хорооны вэб хуудсанд тавьсан 2015 оны Хяналт, шалгалт явуулах хүсэлтэнд өгсөн Удирдлагын хариулт, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан болно.¹⁰ Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны хяналтыг сайжруулсан нь ХНУ-ний эхний төслийг дахин хэлэлцүүлэх, тэдгээр хэлэлцүүлгийн үр дүнд гарсан санал дээр үндэслэн ХНУ-ний төслийг шинэчлэн боловсруулах, ХНУ-г эцэслэн гаргахаас өмнө дахин нийтэд ил болгож, нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулахыг Төслөөс шаардах гэх зэрэг алхмуудаас мөн харагдаж байна. Удирдлага нь тус Банкны бодлогын хүрээнд олон нийтээр хэлэлцүүлэх сайн туршлагыг үргэлжлүүлэхээр Зээлдэгчтэй хамтран ажиллах болно.

Агаарын бохирдол

47. *ДЦС-ын агаарын бохирдолд үзүүлэх нөлөөллийг ДЦС-ын БОННУ-нд авч үзэх нь зүйтэй. Банк нь ДЦС-тай холбогдуулан аливаа дэмжлэг үзүүлэхгүй байгаа болно. Хүсэлт гаргагчдын дурдсан болзошгүй хор уршиг нь Төслөөс санхүүжүүлж буй судалгаанаас биш зөвхөн ДЦС-аас үүдэж боломжтой. ДЦС-аас ялгарах болзошгүй бохирдлыг хүлээн авах агаарын урсгалыг ХНУ-ний хүрээнд байгаль орчны эрсдэлийг нэг гэж тооцон үнэлэх болно.*

¹⁰ <http://ewebapps.worldbank.org/apps/ip/Pages/ViewCase.aspx?CaseId=107>

48. *Удирдлага нь Хүсэлт гаргагчдын нэгэн адил Улаанбаатар хотын агаарын бохирдолд санаа зовниж буй юм. Багануур нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын нэг хэсэг ч гэсэн*

хотоос алслагдсан, чухамдаа хотын төвөөс 100 гаруй км-ийн алсад байрладаг. Гэсэн хэдий ч олон жижиг хот, тосгонд агаарын бохирдол асуудал болж байгаа бөгөөд шинэ станцын бохирдлын нөлөөллийг судлах нь зүйтэй.

47. *Улаанбаатар хотод нарийн тоосонцор ялгаруулагч үндсэн эх үүсвэрүүд нь төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбогдоогүй, хотын захад гэрт аж төрдөг¹¹ олон зуун мянган өрхүүдийн ашиглаж буй уламжлалт, үр ашиггүй, өндөр бохирдол ялгаруулдаг нүүрсээр галладаг зуух юм.* Банкны Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл болоод бусад төслөөс сайжруулсан зуухад дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд бохирдлын түвшин өндөр хэвээр байгаа боловч бохирдлын түвшин хамгийн их буурсан жилүүд нь зуух тараасан жилүүд байна. Удирдлага нь бусад арга барилыг хэрэгтэй гэдэгтэй гэдэгт санал нэг байгаа ба МУЗГ цэвэр түлшинд тэргүүлэх ач холбогдол өгч байна. МУЗГ-ын одоогийн агаарын бохирдолтой тэмцэх стратеги нь цахилгаан халаагуурын хэрэглээг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын гэр хорооллын дүүргүүдэд 2019 оноос эхлэн түүхий нүүрсний хэрэглээг хорих алхмуудыг онцолж байна. Гэр хорооллын нүүрсээр галладаг зуухыг орлох нөөцлүүртэй цахилгаан халаагуурыг туршиж, дэлгэрүүлэх мөн холбогдох бодлого, тарифын урамшууллыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотын цэвэр агаар төслийн нэмэлт санхүүжилтийг боловсруулж байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах юм.

Ажиллах хүч ихээр шилжин ирэхтэй холбоотой эрсдэл

50. *Удирдлага нь ажиллах хүч ихээр шилжин ирэхтэй холбоотой эрсдэлийг ялангуяа охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалтай холбогдуулан нухацтай авч үзэж байна.* Хэдийгээр ийм эрсдэлүүд нь зөвхөн техникийн туслалцаа үзүүлж буй энэхүү Төсөлтэй холбоотой биш боловч ХНУ-нд Хүсэлт гаргагчдын тавьсан санаа зовниж буй асуудлууд болон бусад ажиллах хүч ихээр шилжин ирэх асуудлуудыг авч үзнэ.

51. *МИНИС төслөөс Багануурын станцад дэмжлэг үзүүлэхгүй байгаа боловч, Удирдлага нь барилгын ажлын үеэр ихээхэн хэмжээний ажиллах хүч шилжин ирэхээс үүдэх нийгмийн нөлөөллийн талаар зовниж буйгаа МУЗГ-т яамны түвшинд хэлэлцэж, зохих арга хэмжээ авах нь зүйтэй гэж зөвлөсөн.* Банк нь уурхайн өргөтгөл болон ДЦС-тай холбоотой нийгмийн асуудлуудыг судлах зорилгоор нийгмийн хамгааллын томилгоот багийг 2018 оны 1-р сард Багануурт ажиллуулсан. Томилгоот баг орон нутгийн Эмэгтэйчүүдийн холбоо болон бусад ТББ-уудтай уулзсан. Тэдгээр оролцогч талууд гадаадын ажиллах хүч шилжин ирэхтэй холбоотой асуудлуудыг хөндсөн.¹² Банк нь ийм асуудлуудыг нухацтай авч үзэх шаардлагатай гэдгийг Зээлдэгчид онцолсон бөгөөд ХНУ-г хянах талаар явуулах яриа хэлэлцээрийн хүрээнд эдгээр асуудлаар Зээлдэгчтэй үргэлжлүүлэн хэлэлцэх болно. Удирдлага нь ДЦС-ын эхний ээлжийн ажилчдын баазыг барьсан боловч барилгын ажил түр зогссон гэж ойлгож байна. Уурхайн өргөтгөлийн барилгын ажил эхлээгүй байгаа болно.

Гүний усны удирдлага (хоёрдугаар Хүсэлт)

52. *МИНИС төсөл нь ус нэн ховор Өмнө говийн бүсэд гүний усны менежментийн чиглэлээр ихээхэн хувь нэмэр оруулсан байгаа.* Төслийн гүйцэтгэх үүрэг нь төрийн байгууллага болох СГЗ-д болон иргэний нийгмийн төлөөлөл болоод бусад оролцогч талуудаас бүрдэх СГЗӨ-үүдийг байгуулж, чадавхыг нь дэмжих болно. Үүнд сургалт явуулах, Өмнө говьд байрлах техникийн болон бусад мэргэжилтнүүдийг авч ажиллуулж, цалинжуулах, техникийн шинжилгээ, судалгааг санхүүжүүлэх болон захиргааны дэмжлэг үзүүлэх зэрэг багтана. Уг дэмжлэгийн зорилго нь Засгийн газар (СГЗ-даар дамжуулан), иргэний нийгэм гэх мэт өргөн хүрээний оролцогч талууд

¹¹ Малчдын өргөнөөр хэрэглэдэг гэр нь ихэвчлэн шугамд холбогдоогүй байдаг.

¹² Уурхайн өргөтгөл болон ойр орчмын төслүүдийн талаарх дата, мэдээлэл ил болгох; уурхайн өргөтгөлд нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай талаар тодорхой биш; ИНБ-уудаас оролцоог хангах талаар тавьж буй шаардлага; болон ХНУ-ний төслийн чанарын талаар санаа зовниж буй гэх зэрэг асуудлууд багтсан.

(СГЗӨ-үүдээр дамжуулан)-ад усны нөөцийг хянах, бүс нутаг дахь усны оролцогч талуудын уялдааг хангах болон 2012 Усны тухайн хуульд заасанчлан хэд хэдэн УННМТ-г боловсруулахад туслалцаа үзүүлэх болно.¹³

53. **Төслөөс гурван СГЗ-дыг байгуулж, СГЗӨ-ийн тооны хурлыг амжилттай дэмжих ажлаа амжилттай хэрэгжүүлж, улмаар уг бүс дэхь гүний усны менежментэд хандах институцийн арга барилыг сайжруулсан.** Тиймээс МИНИС-ээр дамжуулан хэрэгжүүлэх Банкны оролцоо нь Засгийн газарт техникийн мэдээллээр хангах, энэхүү процессийн хүрээнд илүү олон оролцогч талуудыг оролцуулах замаар усны хомс нөөцийн ашиглалтын талаарх институцийн шийдвэр гаргалтыг бэхжүүлэхэд тус нэмэр болж буй юм. Төсөл 2014 онд СГЗ-дыг дэмжиж эхэлснээс хойш Өмнө говийн гурван СГЗ-д гүний усны нөөцтэй холбоотой мэдээлэл нэгтгэж, олон оролцогч талуудтай харилцаж, гурван сав газарт УННМТ-г боловсруулж эхлээд байна. УННМТ-нүүд нь хэт шавхалтаас үүдэх усны хомсдолд орохоос сэргийлэхийн тулд суурин газруудын ундны усны хэрэгцээ гэх зэрэг сав газрын түвшин дэх бүхий л хэрэглээнд ашиглах боломжтой усны нөөцийг тооцоог хамарч буй юм. УННМТ-нүүд нь сав газар дахь ус ашиглагчид болон хувь хүмүүс гэх зэрэг оролцогч талуудтай хамтран ажиллах замаар усыг хамгаалах, түгээх, ашиглах, дахин боловсруулах болоод усны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлох юм. Төслөөс үзүүлсэн дэмжлэг нь Засгийн газар гүний усны нөөцийн талаарх мэдээллийг бүрдүүлэх, СГЗ-үүдээр дамжуулан оролцогч талуудад усны асуудлаар Засгийн газартай харилцах суваг бий болгох, эцэст нь УННМТ-нүүд болон холбогдох хэлэлцүүлгээр дамжуулан олон нийтэд илүү их мэдээлэл авах нөхцөлөөр хангах зорилготой юм.

54. **хэлэлцүүлэг явуулах гэх зэргээр СГЗ-д болон СГЗӨ-үүдийн ажилтай холбоотой оролцогч талуудын оролцоог хөнгөвчлөхөд чиглэсэн дорвитой хүчин чармайлт гаргасан.** СГЗӨ-ийн уулзалтууд нь гурван сав газар тухай бүрт (Алтайн, Галба болон Умард) явагддаг тул сав газарт тулгарч буй усны нөөцийн гол асуудлуудыг хэлэлцэх, өөрсдийн зовниж буй асуудлуудыг дэвшүүлэх боломжийг гол оролцогч талуудад олгодог. Жишээлбэл, Алтай-Өвөр Говийн СГЗӨ нь 2016 оны 2, 4-р сар, 2017 оны 6 болон 11-р сард тус тус уулзалт зохион байгуулсан. Умардын СГЗӨ нь 2016 оны 6-р сар, 2017 оны 5 болон 11-р сард уулзалт зохион байгуулсан. Галбын СГЗӨ нь 2016 оны 4, 11-р сар, 2017 оны 5 болон 11-р сард тус тус уулзалт зохион байгуулсан байна. МИНИС-ийн ТҮН-ийн төлөөллүүд эдгээр уулзалтуудын ихэнхэд оролцсон болно. СГЗӨ нь иргэний нийгэм, хувийн хэвшил болон анхны уулзалтанд оролцсон бусад бүлгүүдийн төлөөллөөс бүрдсэн 41-45 гишүүнтэй. Ээлжит уулзалтанд оролцох бүх гишүүдэд 15 хоногийн өмнө мэдэгддэг. Уулзалтын үеэр жилийн төлөвлөгөө, ялагдаж буй үйл ажиллагаа, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэлэлцдэг бөгөөд явцын тайлан, гүний усны загварчлалын ерөнхий асуудлууд, МИНИС төслийн үйл ажиллагаа, тусгай төслийн талаарх мэдээлэл, мониторингийн сүлжээ болон орц, Төслөөс санхүүжүүлсэн “Орхон”, ”Шүрэн”-гийн төслийн судалгааны хэлэлцүүлгийн үр дүн гэх зэргийн мөн авч үзлэг. Уулзалтуудыг баримтжуулж, СГЗӨ-ийн вэб хуудас эсхүл нийгмийн сүлжээнд тавьдаг.¹⁴

55. **СГЗ-д болон СГЗӨ-үүдэд Төслөөс үзүүлэх дэмжлэг нь үндсэндээ чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн тул Төслөөс үзүүлж буй дэмжлэг болон Хүсэлт гаргагчдын дурдсан уул уурхайн лиценз олгох үйл ажиллагаа хооронд уялдаа байхгүй юм.** Төсөл нь Гурвантэс суманд ямар нэг уул уурхайн хөрөнгө оруулалтад шууд оролцоогүй бөгөөд Банк нь уул уурхайн тэдгээр үйл ажиллагаатай холбоотой өвчлөлийн эрсдэлийг удирдах эсхүл нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанд ямар нэг үүрэг оролцоо байхгүй юм. СГЗ-д нь уул уурхай, хөдөө аж ахуй болон бусад салбарт тухайн ус ашиглах төслийн хэмжээнээс хамааран жил бүр ус ашиглалтын зөвшөөрөл олгоход чиглэгдсэн янз бүрийн үүрэг хүлээдэг. Томоохон төслүүдэд¹⁵ буюу өдөрт 100м³ -ээс дээш усны хэрэглээтэй (үүнд томоохон уурхайнууд орно) этгээдийн хувьд Байгаль орчны яамнаас төслийн ТЭЗҮ-г хянан үзэж, урт хугацааны зөвшөөрөл олгох эсэхээ шийдвэрлэдэг. Өдөрт 50-100м³-ийн хэрэглээтэй төслүүдийн хувьд СГЗ-д өргөдлийг хянан үзэж, зөвшөөрөл олгох нь зүйтэй

¹³ 2012 оны Усны тухай хуульд СГЗ болон СГЗӨ-ийн чиг үүргийг тодорхойлсон байдаг. СГЗ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шууд харьяан доор үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага ба Усны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сав газрын удирдлага, зохицуулалтаар хангах үүрэгтэй юм. СГЗӨ нь усны менежментийн төлөвлөгөө боловсруулах, зөвлөмж гаргах, үйл ажиллагаанд хяналт тавих болоод олон талын оролцоог хангах үүрэгтэй. СГЗӨ-д нутгийн удирдлага, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сум, дүүргийн иргэд, ус ашиглагчид, эрдэмтэн судлаачид болон усны мэргэжлийн байгууллагын төлөөллийг багтаах шаардлагатай.

эсэх талаар аймгийн байгаль орчны газарт зөвлөмж хүргүүлдэг. СГЗ нь уул уурхай лиценз олгоход дэмжих эсхүл лиценз олгоход нарийн мэргэжлийн хяналт тавихад ямар нэг байдлаар оролцдоггүй болно.

56. **Төсөл нь Өмнө говийн гурван СГЗ-дад УННМТ-г боловсруулахад одоо дэмжлэг үзүүлж буй юм.**¹⁶ Гүний усны менежментийн хувилбаруудыг үнэлэхэд байгаль орчин, нийгмийн болзошгүй

сөрөг нөлөөллийг үнэлэх шаардлагатай болж болох тул Банкны зүгээс МИНИС төслийн судалгаанд зориулан боловсруулсан мэдээллийг нийтэд ил болгох, хэлэлцүүлэх удирдамжийн дагуу УННМТ-г орон нутгийн ТББ-ууд гэх зэрэг оролцогч талуудаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж Зээлдэгчид мэдэгдсэн бөгөөд Засгийн газар энэхүү зорилгоор олон нийтээр хэлэлцүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулсан болно.¹⁷ Удирдлага нь нийтээр хэлэлцүүлэх төлөвлөгөөнд санал өгч буй бөгөөд Банкны бодлогын холбогдох шаардлагуудыг тусгах нөхцөлөөр хангахаар Зээлдэгчтэй хамтран ажиллаж буй юм. УННМТ-ний ажил явагдаж байгаа бөгөөд 2018 оны эцэс гэхэд эцэслэн боловсруулж, хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна.

57. УННМТ нь бүс нутаг дахь одоогийн болон ирээдүйн усны нөөцийн чиг хандлагыг ерөнхийлөн харахаас гадна усны нөөцийн менежменттэй холбоотой олон асуудлуудыг авч үзэх юм. Үүнд бүс нутагт төлөвлөсөн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн шинжилгээ, усны нөөцийн ашиглалтын чиг хандлагын мэдээлэл багтана. Төслөөс УННМТ гэх мэт гүний эсхүл гадаргын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэхдээ хамааралтай хэмжээнд болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудлуудыг авч үзэх юм. Нөлөөлөлд өртөж болох талуудын саналыг авах үүднээс оролцогч талуудын оролцуулан зохих ёсны хэлэлцүүлэг (эдгээр шаардлагууд нь УННМТ-ний АД-т орж тусгагдсан). Хэлэлцүүлгүүдийг Банкны шаардлагуудын дагуу энэ жилийн эцсээр явуулах төлөвлөгөөтэй байна. УННМТ дээр ажиллаж буй зөвлөхүүд анхан шатны оролцогч талуудад хүрч ажиллах арга хэмжээг явуулсан. УННМТ-ний зөвлөх болгон СГЗӨ-ийн холбогдох уулзалтанд оролцсон болно. Түүнчлэн тэд өөрсдийн тайланг боловсруулах зорилгоор сум, баг, байгаль орчны мэргэжилтэн, орон нутгийн аж ахуйн нэгж, малчид болон ТББ-уудтай тусдаа уулзалт хийсэн. Хавсралт 4-т оролцогч талуудтай очиж хийсэн уулзалтуудын жагсаалтыг харуулсан болно.

58. МИНИС төсөл нь гүний усны бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой олон тооны янз бүрийн чиглэлийн жижиг техникийн судалгаануудыг санхүүжүүлж буй юм. Эдгээр тайлангуудад жижиг судалгаанаас авахуулаад техникийн үнэлгээ болон түүвэр судалгаа орж буй юм. Мэдээлэл нийтэд ил болгох шаардлага ОР/ВР 4.01-т техникийн судалгаа хамаардаггүй тул Төслийн БОНМХ-нд гүний усны судалгаа, чанарын үнэлгээ, түүвэр судалгаа, зураг, аргачлал болон судалгааны төлөвлөгөөг хамгааллын хэрэгсэл ашиглах эсхүл хэлэлцүүлэх болон олон нийтэд ил болгох шаардлагагүй гэж тодорхой заасан болно. Түүнчлэн эдгээр судалгааны олон нь Банкны мэдээллийн хүртээмжийн бодлого (“гишүүн орон болон гуравдагч этгээдийн нууцлалын зэрэгтэй олгосон мэдээлэл” гэх Мэдээллийн хүртээмжийн бодлогын хэсэг 2(g))-ын дагуу ил болгохгүй байх онцгой нөхцөлд хамаарч буй юм. Гэсэн хэдий ч Удирдлага нь МУЗГ-ыг аль болох их мэдээлэл ил болгохыг дэмжиж ирсэн ба МУЗГ-аас эдгээр судалгааны гурвыг¹⁸ нь нийтэд ил болгосон ба дөрөв дэхийг нь ил болгох эсэхийг авч хэлэлцэж буй юм. Түүнчлэн Банкны зүгээс өөр судалгаануудыг Монгол Улсын хуулийг зөрчилгүйгээр ил болгох боломжтой эсэх талаар Засгийн газартай яриа хэлэлцээр өрнүүлж байна. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан техникийн судалгаа болон тэдний ил болсон эсэх статусыг Хавсралт 3-аас харна уу.

¹⁴ Жишээлбэл дараахыг харна уу : <http://altai.gobiwater.mn/>; https://www.facebook.com/galba.zuvlul/?ref=br_rs;

https://www.facebook.com/umard.gobi?ref=br_rs

¹⁵ 2012 оны Усны тухай хуульд үндэслэв. Ойлгомжтой болгох үүднээс дурдвал Өмнө говийн томоохон уурхайд дунджаар өдөрт 10,000-58,000 м³ ус ашиглах зөвшөөрөл олгосон байдаг.

¹⁶ Алтайн, Галба болон Умардын сав газрын УННМТ-нүүд орсон болно.

¹⁸ 2017 оны 6-аас 7-р сард хийсэн томилгоот ажлын тэмдэглэлийг харна уу.

VI. ДҮГНЭЛТ

59. *Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд нь Банкнаас үзүүлж буй техникийн зөвлөмжийн мэдээлэлд үндэслэж болох ирээдүйн хөрөнгө оруулалтаас үүдэж болзошгүй хор уршигт төвлөрч буй юм. Тиймээс, Удирдлага нь тус Банкнаас үзүүлж буй техникийн туслалцааг түүнийг бэлтгэх (үүнд мэдээлэл нийтэд ил болгох ба хэлэлцүүлэх), түүний дүгнэлт болон зөвлөмж гаргахад дагах процесстой холбоотой болон бусад Банкны бодлоготой нийцүүлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч байна.* Удирдлага нь Төслийн хүрээнд санхүүжүүлж буй судалгаанууд МУЗГ-г ируудүйн хөрөнгө оруулалтыг авч үзэж, шийдвэр гаргахад тус болох объектив болоод оновчтой мэдээллийн суурь бүрдүүлэх нөхцөлөөр хангахад тууштай зүтгэнэ. Удирдлага нь МИНИС төслийн хүрээнд судалж буй аливаа санал болгосон хөрөнгө оруулалтын барилгын ажлыг санхүүжүүлээгүй ба тэдгээрийн санхүүжүүлэх ямар нэг шийдвэр эсхүл амлалт өгөөгүй болно. Хүсэлт гаргагчдын тавьсан олон асуудлууд нь Банкны дэмжлэгтэй уг төсөлтэй холбоогүй байна.

60. *Банк нь Багануурын уурхайн ойр байрлах ДЦС-ыг санхүүжүүлээгүй болно. Түүнчлэн, Банк нь Хүсэлт гаргагчдын гүний усны ашиглалттай холбоотой дурдсан уул уурхайн үйл ажиллагааны алинд ч оролцоогүй болно.* Гэсэн хэдий ч Удирдлага нь Хүсэлт гаргагчдын дурдсан эрсдэлүүдийг оновчтой үнэлж, бууруулах шаардлагатай гэдэгтэй санал нэг байна. Удирдлага нь МИНИС төслийн хүрээнд боловсруулах судалгаа, төлөвлөгөөний чанартай байдлыг дэмжихэд хянуур ажилласан хэвээр байх болно.

61. *Удирдлага нь Төслийн хүрээнд үзүүлж буй техникийн туслалцаа нь МУЗГ-ын зүгээс цаашид ямар нэг хөрөнгө оруулалтыг дэмжих талаар гаргах шийдвэрийг урьдчилан тодорхойлохгүй бөгөөд/эсхүл албадан зөвшөөрүүлэх нөхцөл үүсгэхгүй юм.* Мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай объектив мэдээллийн суурийг тавих зорилготойгоор Удирдлага нь Төслийн зүгээс санхүүжүүлж буй хараат бус зөвлөхийн хийх үнэлгээнүүд болоод тэдгээр үнэлгээний зөвлөмжийг хүлээн авах эсхүл хэрэгжүүлэх эсэх талаар гаргах МУЗГ-ын шийдвэрийн хооронд нарийн ялгаж, салгаж ойлгох шаардлагатай гэж итгэж буй юм.

62. *Удирдлага нь Хүсэлт гаргагчдын тавьсан асуудлууд, нэн ялангуяа судалгааны чанар, мэдээллийг нийтэд ил болгох болон нийтээр хэлэлцүүлэхтэй холбоотой, ХНҮ-ний хамарч буй асуудлын талаар дэвшүүлсэнд талархаж байна.* Эдгээр санаа зовниж буй асуудлуудыг урьд өмнө нь илэрхийлсэн байсан бөгөөд тэдгээрийг ХНҮ-ний ажлын даалгавар болон ХНҮ-ний шинэчилсэн төсөлд тусгасан болно. Удирдлага нь ДЦС-ын төслийн хөгжүүлэлт, ажиллах хүч ихээр ирэх шилжилт хөдөлгөөн, аюулгүй байдал, эрүүл мэндийн нөлөөлөл болон агаарын бохирдлын асуудал гэх зэрэг Хүсэлт гаргагчдын тавьсан асуудлуудыг ХНҮ-нд зохих ёсоор хамруулахаар Зээлдэгчтэй ойр ажиллах болно. Удирдлага нь оролцогч талуудыг оролцуулах, мэдээлэл нийтэд ил болгох, нийтээр хэлэлцүүлэхтэй холбоотой Банкны хамгааллын шаардлагуудад хамаарах баримт бичгийг хэлэлцүүлэх чиглэлээрх Засгийн газрын хүчин чармайлтыг хянаж ажилласан хэвээр байх болно.

63. *Банк нь Төсөлтэй холбоотой хяналтын үүргээ биелүүлж байгаа бөгөөд сүүлийн 18 сард өөрийн үйл ажиллагааг нилээдгүй сайжруулж чадсан МИНИС-ийн ТУН-ид хэрэгжилтийн дэмжлэг үзүүлж, ойр ажилласаар ирсэн.* Энэхүү ахиц дэвшлийг 2015 оны Хяналт, шалгалт явуулах хүсэлтийн хариуд авч хэрэгжүүлсэн оролцогч талуудыг оролцоог хангахтай гарсан томоохон дэвшлээс жишээ болгон харж болох юм. Банкны баг нь МИНИС-ийн ТУН-тэй хамтран иргэний нийгэм болон нутгийн иргэдэд цаг алдалгүй дэлгэрэнгүй хариулт тууштай өгсөн.

¹⁸ Эдгээрт: усны салбарын нэр томъёоны стандарт, гүний усны хайгуул хийх аргачлал болон ураны ордтой гзар гүний усны судалгаа хийх аргачлал орно. Ил болгохоор харгалзан үзэж буй дөрөв дэхь судалгаа нь гүний усны хайгуулын нэгж төсөв тооцоолох удирдамж орно.

ХАВСРАЛТ 1
ГОМДОЛ БОЛОН ХАРИУЛТ- 18/02

| № | Гомдол | Тайлбар |
|----|---|--|
| 1. | <p><i>Бүрэлдэхүүн хэсэг 1:</i> Багануурын нүүрсний уурхайн өргөтгөл. Багануурын уурхайн өргөтгөлд төлөвлөсөн ТЭЗҮ болон ХНҮ нь Төслийн энэхүү хэсэгт орсон. Өргөтгөлийг боломжтой болгох бүхий л судалгаануудыг эцэслэн боловсруулсан боловч ТЭЗҮ болон ХНҮ-г аль алиныг нь олон жил огт боловсруулаагүй. 2016 оны ХНҮ-ний эхний төсөлд холбогдох байгууламж болох РЕДАКЦИН ЗАСВАР 700 МВ-ын нүүрсээр ажиллах станцыг оруулаагүй. Шинэчилсэн ХНҮ-г төлөвлөсөн бөгөөд АД-ыг ил болгоогүй. АД-ыг ил болгоогүй байгаа боловч ХНҮ-г боловсруулахаар томилогдсон зөвлөхтэй ярилцахад шинэчилсэн ХНҮ-нд эрчим хүчний станцыг оруулахгүй байх магадлалтай гэсэн. Станцын барилгын ажил 2017 оны зун эхэлсэн бөгөөд 2018 оны 4-р сард барилгын улирлаар дахин эхэлнэ. Хамааралтай байгууламж болох нүүрсээр ажиллах эрчим хүчний станц нь иргэдэд нэн ялангуяа жендэр, хүүхдүүд болон эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлалтай ба эдгээрийг Багануурын РЕДАКЦИН ЗАСВАР-аас ирсэн гомдолд тодорхойлсон байгаа. ОР 4.01-д ийм нөлөөллийг үнэлэх, төслийн байгаль орчин болон нийгмийн баримт бичигт эдгээр сөрөг нөлөөллөөс (зайлсхийх арга хэмжээг тодорхойлох)-ыг шаарддаг. Багануурын нүүрсний уурхайн өргөтгөл болон 700 МВ-ын ДЦС-ын БОННҮ-г 2013 болон 2014 онуудад тус тус боловсруулсан. Эдгээр БОННҮ-нд “онолын хувьд” болзошгүй эрсдэлийн жагсаалтыг тусгасан авч нүүрсээр ажиллах хоёр турбинтай 350МВ-ын цахилгаан станцын онцлогтой холбоотой гэх зэрэг орон нутгийн хавсаргасан гомдолд тавьсан асуудлуудыг харгалзан үзээгүй байна. Багануурын нүүрсний цацрагийн түвшин илүү өндөр гэгддэг тул орон нутгийн иргэд уг байгууламжийн агаарын бохирдол болон эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовниж байна. Эдгээр зовниж буй асуудлуудыг 2013</p> | <p>Банк нь Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-г санхүүжүүлсэн ба үүний хүрээнд ХНҮ-г хийх ажлыг мөн санхүүжүүлж буй юм. Багануурын нүүрсний уурхай ДЦС-тай ойр байрладаг бөгөөд санал болгосон нүүрс нийлүүлэх тохиролцооноос үүдэн ДЦС-ыг ХНҮ-нд хамруулах ба уг ХНҮ-ний зорилго нь уурхайн нөлөөллийн бүсэд үзүүлэх уурхайн өргөтгөлийн хуримтлагдах нөлөөллийг үнэлэх юм.</p> <p>2015-2016 онд хийгдсэн ТЭЗҮ нь үлдсэн нилээдгүй их нүүрсний нөөц болон нүүрсний эрэлтийн өсөлтийн прогноз дээр тулгуурлан тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх, шинэ арга, технологийг нэвтрүүлэх замаар 40 жилийн настай Багануурын уурхайн нүүрсний үйлдвэрлэлийг өргөтгөх эдийн засгийн хувилбаруудыг тодорхойлох зорилготой байсан. ТЭЗҮ-г хийх үеийн 3.5-3.9 ст/ж уурхайн хүчин чадлыг 10ст/ж болон нэмэгдүүлэхэд зардлаа нөхөж, үйл ажиллагааны нэгж зардлаа бууруулах боломжтой гэж ТЭЗҮ-нд дүгнэсэн. Ийнхүү өргөтгөх нь Багануурын уурхайгаас нүүрс авах олон шинэ хэрэглэгчдийг бий болгоно гэж төсөөлсөн.</p> <p>ТЭЗҮ-д уурхайн өргөтгөлөөс олборлох нүүрсийг худалдан авагчийг бий болгох нүүрсд суурилсан эрчим хүчний эх үүсвэрийн болзошгүй хөрөнгө оруулалтын төслүүдийг тодорхойлсон, үүнд: (1) ДЦС 4 болон Дарханы ДЦС-ын өргөтгөл; (2) Амгалангийн ДЦС; (3) ДЦС 5 (цуцлагдсан); (4) Багануурын ДЦС; (5) бага хүчин чадалтай хэд хэдэн цахилгаан станцууд; болон (6) нүүрснээс хий гаргаж авах хэд хэдэн төслүүд тус тус орсон.</p> <p>Одоогийн байдлаар МУЗГ-аас дээр дурдсан хөрөнгө оруулалтын алийг ажил хэрэг болгох нь тодорхойгүй байна. Жишээлбэл, ДЦС 5 нь ТЭЗҮ-г хийх үед төлөвлөгдсөн байсан боловч дараа нь цуцлагдсан. Багануурын ДЦС-ын барилгын ажил 2017 онд эхэлсэн боловч 2018 онд зогссон.</p> <p>Уурхайг өргөтгөх ажил хараахан эхлээгүй болно. Зөвхөн ХНҮ болон холбогдох хэлэлцүүлгийг эцэслэн хийсний дараа өргөтгөлийн хөрөнгө оруулалтыг хийх нь зүйтэй гэх агуулга бүхий захидлыг Банкны Удирдлага Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2017 оны 11-р сарын 21-нд хүргүүлсэн.</p> <p>ХНҮ-ний зорилтуудын нэг нь санал болгосон Багануурын уурхайн өргөтгөлийн БОННҮ-г шинэчлэн боловсруулах мэдээллээр хангах юм. МУЗГ нь (МИНИС төслийн оролцоогүйгээр) 2013 онд БОННҮ-г боловсруулсан. Засгийн газар нь Монгол Улсын хуулийн дагуу БОННҮ-г таван жил тутам шинэчлэх шаардлагатай бөгөөд эцэслэсэн ХНҮ болон ТЭЗҮ-ний үр дүнг ашиглан БОННҮ-г хуулийн дагуу шинэчлэх юм.</p> <p>ХНҮ-г 2014 онд хийж эхэлсэн ба 2018 оны эцсээр</p> |

болон 2014 оны БОНУ-нүүд болон АД-уудад авч үзээгүй.

боловсруулж дуусахаар төлөвлөж буй юм. ХНУ-ний анхны төслийг 2015 оны 9-р сард нийтэд ил болгон хэлэлцүүлсэн. Орон нутгийн засгийн газар, ТББ/ИНБ-ууд болон нутгийн иргэд гэх зэрэг төлөөллийг хамарсан 79 хүн хэлэлцүүлэгт оролцсон. Удирдлага нь ХНУ-ний төсөл нь чанарын хувьд Банк хүлээн авах боломжгүй гэж үзсэн. Удирдлага нь ХНУ-ний анхны төслийг боловсруулсан эхний зөвлөхтэй хийсэн гэрээг цуцлахыг Зээлдэгчид зөвлөсөн. Түүнчлэн Банк нь олон нийтийн хэлэлцүүлэгт баримтлах сайн туршлагыг ХНУ-ний төсөлд дагаж мөрдөөгүй гэж үзсэн бөгөөд Зээлдэгч нь тус Банкны шаардлагын дагуу хоёр дахь хэлэлцүүлгийг 2018 оны 4-р сард явуулсан болно. Хоёр дахь хэлэлцүүлэгт Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Багануурын ЗДТГ, бусад хорооны дарга болоод ахлах албан тушаалтнууд, ЖДҮ-ийн газар, орон нутгийн ТББ, Төв аймгийн Буяндэлгэр сумын ЗДТГ, Багануур уурхай ХХК болон хувийн хэвшлийн бусад төлөөлөгчид, нутгийн иргэд болон ИНБ-уудын төлөөллийг хамарсан нийт 81 хүн оролцсон.

Уг хоёр хэлэлцүүлэг болон 2014 онд явагдсан ХНУ-ний АД-ын төслийн хэлэлцүүлгийн талаарх дэлгэрэнгүй МИНИС төслийн вэб хуудас болох

<http://minis.mn/en/p/baganuur-cia> -д байрлах хэлэлцүүлгийн материалаас харах боломжтой.

Олон улсын зөвлөх авч ажиллуулах, зөвлөхийн ажлын хамрах хүрээг тодорхойлох ажлыг хөнгөвчлөх зорилгоор ХНУ-г шинэчлэн боловсруулахад зориулсан шинэ АД-т оролцогчдын энэхүү хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн саналыг тусгасан болно. Банк нь Төслийн вэб хуудсан дээр АД-ыг нийтэд ил болгохыг Зээлдэгчид зөвлөх болно. Туршлагатай олон улсын зөвлөх 2016 оноос хойш ХНУ-г шинэчлэх ажил дээр ажиллаж байна.

ХНУ-ний төслийг шинэчлэн боловсруулахаар Зээлдэгчийн авч ажиллуулж буй зөвлөх нь хэлэлцүүлгийн үеэр оролцогч талуудаас тавьсан санаа зовниж буй асуудлууд болоод тэдний саналыг авч үзэн судалгааны одоо байгаа хамрах хүрээг хянаж, шинэчлэн боловсруулах тодорхой чиглэл авсан болно.

Төслийн баг нь ХНУ-ний хэд хэдэн төслийг хянан үзэж, Зээлдэгчид саналаа хүргүүлсэн. Зөвлөх нь одоогийн байдлаар 2018 оны 4-р сард хамгийн сүүлийн удаа авсан санал дээр үндэслэн ХНУ-г шинэчлэн боловсруулж байна. Банк нь ХНУ-г хангалттай гэж үзэх хүртлээ хянах процессийг үргэлжлүүлнэ. Одоогийн шинэчлэн боловсруулалт эцэслэгдэн дууссаны дараа ХНУ-г дахин нийтэд ил болгож, хэлэлцүүлнэ.

Багануурын уурхайн өргөтгөлд үзүүлэх Төслийн дэмжлэгийг хуваарийг доор хураангуйлан харуулав:

| Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | |
|-----------------------------------|------------------------|
| ХНУ-ний АД-ын төслийн хэлэлцүүлэг | 2014 оны 11-р сарын 21 |
| ХНУ-ний төслийн хэлэлцүүлэг #1 | 2015 оны 9-р сарын 28 |
| ХНУ-ний төслийн хэлэлцүүлэг #2 | 2016 оны 4-р сарын 8 |
| ТЭЗҮ-г боловсруулж дуусгах | 2016 оны 4-р сар |
| Төлөвлөсөн үйл ажиллагаа | |
| ХНУ-ний төслийн хэлэлцүүлэг #3 | 2018 оны эцэс |
| ХНУ-г шинэчилж, эцэслэх | 2018 оны эцэс |

| | | ТЭЗҮ-г шинэчилж, эцэслэх | 2018 оны эцэс |
|----|--|--|---------------|
| | | <p>Эцэслэн боловсруулагдсаны дараа ХНҮ нь ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулахад ашиглах мэдээллээр хангах юм.</p> <p><i>Цацраг.</i> 2012 болон 2013 оны Багануурын нүүрсний цацраг идэвхийн хамгийн сүүлийн тайланг хянаж үзвэл Багануурт олборлодог нүүрсний масс дахь цацрагийн хэмжээ нь хэвийнээс бага түвшинд байна гэж ТЭЗҮ-д тусгасан байна (ТЭЗҮ, хэсэг 4.6.5). Тектоникийн буюу үет давхаргаас хамааралтай (ө.х. гадаргатай ойр исэлдлийн бүс буюу илүү шингэн урсаж, уран баяжих цууралт үүссэн “нугарсан” нүүрсний ан цавтай хэсэг) зарим далд зарим нэг бүсүүдэд цацрагийн хэмжээ өндөр байна. Эдгээрийг тусгаарлаж, нүүрс болон эрдсийн давхрагыг тусгайлан цэвэрлэх/зайлуулах зорилгоор урьд өмнө нь тодорхойлсон.</p> <p>Дээд давхарга дахь (ө.х. нүүрсэн дээрх материал) болон нүүрсний давхаргуудын дундах элс, хайрга дахь цацрагийн фон дундаж үзүүлэлттэй байгаа бөгөөд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр барилгын материалд ашиглахаар зөвшөөрөгдсөн. Үүнтэй адилаар Багануурын нүүрсийг түлдэг ДЦС-уудаас авсан үнсний дээж бага цацрагийн түвшинтэй байна.</p> <p>Монголын стандартын дагуу үнсийг барилгын материалд ашиглах нь зөвшөөрөгдсөн байдаг.</p> <p>Банкны төслийн баг нь Багануурын ДЦС болон нүүрс, нүүрсний үнсний цацраг идэвхийг шинэчилсэн ХНҮ-нд зохих ёсоор тусгуулах нөхцөлөөр хангана.</p> | |
| 2. | <p>Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (МИНИС) нь бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээндээ Багануурын уурхайн өргөтгөлийг ТЭЗҮ-ийг судалж, түүнээс үүдэж болзошгүй хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийж байгаа гэж бид ойлгож байна. ТЭЗҮ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний баримт бичиг нь “нууц материал” гэж ангилагдан бараг хоёр жил болж байгаа бөгөөд материалыг ил болгох шаардлага тавимагц “удахгүй ил болгоно” гэх статустай болсон байгаа нь бид ямар нөлөөлөлд хэзээ, хэрхэн яаж өртөж болох талаар судалж, ойлгох боломж одоог хүртэл хаалттай байна. МИНИС төслийн нууц (ил болгохгүй) гэх статустай судалгааны баримт бичгүүд нь олон нийтийн эрүүл мэнд, байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг нууцлахыг хориглоно гэж тусгасан Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хуулийн 3, 6.1-ийг болон болзошгүй өртсөн хүмүүстэй зөвлөлдөхтэй холбоотой</p> | <p>Төсөл нь мэдээлэл ил болгох болон хэлэлцүүлэхтэй холбоотой Банкны бодлогын шаардлагуудыг хангаж байгаа.</p> <p>ХНҮ-ний төслийг ил болгож, хэлэлцүүлсэн талаар энэхүү Хавсралтын Зүйл 1-т тусган хариулсан болно. Хэлэлцүүлгийн үеэр авсан саналыг тусгах үүднээс ХНҮ-ээг шинэчилж байгаа. Шинэчилж дуусмагцаа ил болгож дахин хэлэлцүүлнэ. ОР/ВР 4.01-т тавьсан шаардлагын дагуу Төслийн байгаль орчин болон нийгмийн эрсдэл, нөлөөллүүдтэй холбоотой мэдээлэл, баримт бичгүүдийг ил болгож, хэлэлцүүлж байгаа. Энэхүү мэдээлэл ил болгох шаардлага нь МИНИС төслөөс санхүүжүүлж буй ТЭЗҮ-д хамаарахгүй юм. Дэлхийн Банк нь ТУН-ийг МИНИС төслөөс санхүүжүүлсэн судалгаанаас аль болох их мэдээлэл нийтэд ил болгохыг уриалж ирсэн бөгөөд Зээлдэгчийн зүгээс ТЭЗҮ-ийг нууц мэдээлэл гэж үзэж буй юм. Тиймээс Удирдлага нь Банкны Мэдээллийн хүртээмжийн бодлогын хэсэг 2(g)-д “гишүүн орон эсхүл гуравдагч этгээдээс нууцлалын зэрэгтэй болгосон мэдээлэл” гэж заасны дагуу ТЭЗҮ-г нууц баримт бичгээр тооцох нь зүйтэй гэж дүгнэсэн.</p> | |

| | | |
|----|---|--|
| | <p>Дэлхийн Банкны Мэдээллийг ил болгох ба зөвлөлдөх хамгааллын бодлогын ОР 4.01-ийг зөрчиж байна.</p> <p>Мэдээллийг хангалттай ил болгохгүй байх: Бид РЕДАКЦЫН ЗАСВАР-т мэдээлэл авахаар хандсан боловч МИНИС төслийн судалгааны дэмжлэгтэй төлөвлөсөн болоод эхэлсэн төслүүдээс үзүүлэх нөлөөллийн талаарх ямар нэг мэдээлэл (захидал харилцааг хавсралтуудаас харна уу) авч чадаагүй. Хятадын компаниуд орон нутгийн засгийн газрын албан хаагчдыг Хятадруу танилцах аялалд авч явсан бөгөөд тэдгээр албан хаагчид одоо дэлхийн хамгийн том яндантай бохирдолгүй ЦС-тай болно гэж хэлж буй авч Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн Банкны мэдээлэл ил болгох бодлогын дагуу шаардагдах ямар ч баримт бичгийг үзээгүй байгаа нь харагдаж байна.</p> | |
| 3. | <p>Хэлэлцүүлэг хангалтгүй эсхүл дутагдалтай: Хэдийгээр МИНИС төсөл нь 2016 онд хэлэлцүүлэг явуулсан гэж тайлагнасан боловч хэлэлцүүлгийн материал болон хариултын хүснэгтүүд одоо болтол ил болоогүй бөгөөд уурхайн өргөтгөл болон холбогдох байгууламжаас үүдэх болзошгүй нөлөөлөл болон бууруулах арга хэмжээний талаар хэлэлцүүлэгт орсон гэх иргэдтэй тааралдаагүй. МИНИС-ийн баг нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний баримт бичгүүдийг сайжруулах талаар мэдээлэх зорилгоор РЕДАКЦЫН ЗАСВАР-т очсон. РЕДАКЦЫН ЗАСВАР нь орон нутгийн засгийн газар, нутгийн иргэд болон иргэний нийгэм (бүлэг болгоноос 5 хүн)-ийн төлөөллүүдээс тэдний уурхай, түүний ирээдүйд хандах хандах хандлага, эерэг болон сөрөг аливаа бодлын талаар 5 асуулт асуухаар бэлтгэсэн байсан. Уг асуултуудад уурхайн өргөтгөл болон холбогдох байгууламжийн талаар ороогүй байсан нь болзошгүй шинэ нөлөөллийн талаар ямар нэг</p> | <p>Банк нь МИНИС-ийн ТУН-ийн оролцогч талуудын оролцоог хангах чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр Зээлдэгчтэй хамтран ажиллаж ирсэн бөгөөд үүний үр дүнд 2015 оны Хяналт шалгалт явуулах хүсэлтээс хойш нэлээдгүй ахиц гарсан. Удирдлага нь Зээлдэгч энэхүү чадавхаа ашиглан цаашид зохих ёсны оролцогч талуудын хэлэлцүүлэг явуулна гэдэгт итгэлтэй байна.</p> <p>Хорооноос хяналт шалгалт явуулахгүй байх зөвлөмж (2017 оны 7-р сарын тайлан) гаргахад хүрсэн 2015 оны Төсөлд хяналт шалгалт явуулах хүсэлт (Хяналтын хороо RQ15/03)-ийн дараа Банк нь олон улсын практикт нийцсэн хэлэлцүүлэх явуулах ТУН-ийн чадавхыг сайжруулах зорилгоор Зээлдэгчтэй ойр ажилласан. ТУН нь оролцогч талуудын оролцоог хангах тал дээр өөрийн гүйцэтгэлийг нэлээдгүй сайжруулсан. Эдгээр хүчин чармайлтын талаарх дэлгэрэнгүйг Хяналтын хорооны вэб хуудсанд тавьсан 2015 оны Хяналт, шалгалт явуулах хүсэлтэд өгсөн Удирдлагын хариулт, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан болно. Удирдлага нь Банкны бодлогын хүрээнд хэлэлцүүлэгтэй холбоотой сайн туршлагыг үргэлжлүүлэх байдлаар Зээлдэгчтэй хамтран ажиллах болно.</p> <p>Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны хяналтыг сайжруулсан нь ХНУ-ний эхний төслийг дахин хэлэлцүүлэх, тэдгээр хэлэлцүүлгийн үр дүнд гарсан санал дээр үндэслэн ХНУ-ний төслийг шинэчлэн боловсруулах, ХНУ-г эцэслэн гаргахаас өмнө дахин нийтэд ил болгож, нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулахыг Төслөөс шаардах гэх зэрэг алхмуудаас мөн харагдаж байна. Удирдлага нь тус Банкны бодлогын хүрээнд олон нийтээр хэлэлцүүлэх сайн туршлагыг үргэлжлүүлэхээр Зээлдэгчтэй хамтран ажиллах болно. Тиймээс Удирдлага нь ХНУ-нд хэлэлцүүлгийн үеэр</p> |

| | | |
|-----------|--|--|
| | <p>мэдээлэлгүйгээр хийдэг хэлэлцүүлгийг процессыг нөлөөллийн үнэлгээнд баримтлахыг харуулж байна. Ямар ч шинэ материал ил болгосон тэдгээр нь бидний дараах асуудалтай холбоотой санаа зовниж буй байдлыг шийдэж чадахгүй байх магадлалтай юм, үүнд а) Багануур дахь охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, нөхөн үржихүйн эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл; б) агаарын чанар ба эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн талаарх үнэн мэдээлэл бүхий тайлан; болон с) хэлэлцүүлгийн чанар өөрчлөгдөж, бодитоор бууруулах эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хэлэлцүүлэх чиглэлд орох магадлал багатай тул шууд нөлөөлөл өртөх иргэдэд мэдээлэл ил болгож бодитоор зөвшилцөхтэй холбоотой Дэлхийн Банкны Хамгааллын бодлогыг зөрчих юм.</p> | <p>тавигдсан асуудлуудыг тусгахгүй гэж дүгнэхэд эрт байгаа гэж үзэж байна.</p> |
| <p>4.</p> | <p>Мэдээлэл ил болгох, хэлэлцүүлэх хандлага болон чанарт хангалттай өөрчлөгдөөгүй: Бид 2015 оноос хойш Оюу Толгой хяналт ТББ, Хил хязгааргүй гол мөрөн эвсэл болон РЕДАКЦИЙН ЗАСВАР-тай хамтран Багануурын хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болон чанарын шаардлага хангахгүй үнэлгээний тайлантай холбогдуулан МИНИС-ийн мэдээлэл ил болгох, хэлэлцүүлэх процессыг сайжруулахаар хичээсэн боловч хүсэмжилсэн мэдээллийг Монгол хэл дээр, ойлгомжтой хэлбэрээр нутгийн нөлөөлөлд өртөх иргэдэд ил болгохыг харж чадсангүй. Зөвхөн Оюу Толгойн хяналт ТББ 2017 оны 10 -р сард Дэлхийн Банкны Нэгдсэн хуралдааны ИНБ-ын арга хэмжээнд панел илтгэлд МИНИС-ийн Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн төслийг хөндсөний дараа бидэнд 2018 оны 1-р сард Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлтэй холбоотой баримт бичгүүдийг ил болгох амлалт өгсөн. 2018 оны 3-р сарын байдлаар ил болгосон ганц баримт бичиг нь нэлээд чанар хангахгүй 2014 оны ХНҮ-ний АД юм http://www.minis.mn/en/report-s-on-baganuur-cia. Өмнөх</p> | <p>Банк нь МИНИС-ийн ТУН-ийн оролцогч талуудын оролцоог хангах чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр Зээлдэгчтэй хамтран ажиллаж ирсэн бөгөөд үүний үр дүнд 2015 оны Хяналт шалгалт явуулах хүсэлтгээс хойш нэлээдгүй ахиц гарсан. Удирдлага нь Зээлдэгч энэхүү чадавхаа ашиглан цаашид зохих ёсны оролцогч талуудын хэлэлцүүлэг явуулна гэдэгт итгэлтэй байна</p> <p>Зүйл 1 болон 3-т өгсөн хариултыг харна уу.</p> <p>2015 болон 2016 онд явуулсан Багануурын ХНҮ-ний хэлэлцүүлгүүд болоод 2014 онд явуулсан ХНҮ-ний АД-ын төсөлд хийсэн хэлэлцүүлгийн дэлгэрэнгүйг http://minis.mn/en/p/baganuur-cia -рүү орж, МИНИС төслийн вэб хуудаст байршуулсан хэлэлцүүлгийн материалуудаас харах боломжтой юм.</p> |

| | | |
|----|---|---|
| | <p>хэлэлцүүлгийн хариултын хүснэгтийг ил болгохгүй, санал болгосон нүүрсний уурхайн өргөтгөл болон холбогдох байгууламжаас үүдэж болзошгүй сөрөг нөлөөллийн талаар ил болгох, болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга замын талаарх мэдээллийг холбогдох нутгийн иргэдэд ойлгомжтой хэлбэрээр тарааж, хэлэлцүүлэх сонирхол дутаж байгаа нь МИНИС төслийн хэрэгжилтийн процесс болон түүнээс гаргасан баримт бичгүүдийн чанарт өөрчлөлт гараагүй нотолгоо болж байна. Энэхүү гомдлын дагалдах баримт бичиг болох хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар эсхүл дээр дурдсан линкийг харна уу.</p> | |
| 5. | <p>Нүүрс олборлолт болон 700 МВ-ын цахилгаан үйлдвэрлэлээс үүдэх агаарын бохирдол: Бид Багануурын уурхайн нүүрсийг түлдэг дэлхийд хамгийн их агаарын бохирдолтой нийслэл хот болох Улаанбаатар хотын Багануур дүүргийн оршин суугчид юм. “Агаарын бохирдол нь Улаанбаатар хотод хүүхдийн эрүүл мэндийн хямралд хүргэж, хүүхэд болоод жирэмслэлт бүрийг эрсдэлд оруулж байна. Эрсдэлд амьгүй ураг төрөх, дутуу төрөх, дутуу жинтэй төрөх, хатгаа, бронхит, астма, тархины хөгжлийн хоцрогдол болон амь насаа алдах орж байна. “Энэ бол Монголын хүмүүн капиталд тулгарч буй бодит аюул” гэж Монгол дахь ЮНИСЕФ-ийн РЕДАКЦЫН ЗАСВАР. Үндэсний Засгийг газар болон Улаанбаатар хотын удирдлагаас 2018 оны 1-р сард онцгой байдал зарлах эсэхийг авч үзсэн (Залуу эмэгтэйчүүд болон хүүхдүүдэд үзүүлж буй Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаарх хэвлэл мэдээллээр гарсан материалын линкийн жагсаалтыг харна уу). Багануурт амьдарч буй бид төлөвлөж буй нүүрсний уурхайн өргөтгөл болон Улаанбаатар хот дахь ДЦС 2, 3 болон 4-ийн суурилагдсан хүчин чадалтай тэнцэх, ижил буюу илүү их нүүрсний утаа болон үнс гаргаж агаар бохирдуулах 700 МВ-ын нүүрсний цахилгаан үйлдвэрлэлээс үүдэх агаарын бохирдолтой тулах вий гэж</p> | <p>Удирдлага нь Хүсэлт гаргагчдын нэгэн адил Улаанбаатар хотын агаарын бохирдолд санаа зовниж буй юм. ДЦС-аас үүдэх болзошгүй бохирдлыг хүлээн авах агаарын урсгалыг ХНҮ-ний хүрээнд байгаль орчны эрсдэлүүдийн нэгээр тооцож судална. Банк нь Монгол Улсын агаарын бохирдлыг бууруулах зорилготой олон ажил дээр Зээлдэгчтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Гэсэн хэдий ч Удирдлага нь Улаанбаатар хот дахь өвлийн улиралд нарийн тоосонцор гаргадаг гол эх үүсвэр нь ДЦС-ууд биш болохыг онцолж байна. Ялгаруулагч үндсэн эх үүсвэрүүд нь төвлөрсөн дулааны шугамд холбогдоогүй, хотын захад гэр (өрхийн эзэмшлийн байшин/гэр)-т аж төрдөг олон зуун мянган өрхүүдийн ашиглаж буй уламжлалт, үр ашиггүй, өндөр бохирдол ялгаруулдаг нүүрсээр галладаг зуух юм.</p> <p>Банкны Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл болоод бусад төслөөс сайжруулсан зуухад дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд бохирдлын түвшин өндөр хэвээр байгаа боловч бохирдлын түвшин хамгийн их буурсан жилүүд нь зуух тараасан жилүүд байна. Удирдлага нь бусад арга барилыг хэрэгтэй гэдэгтэй гэдэгт санал нэг байгаа ба МУЗГ цэвэр түлшинд тэргүүлэх ач холбогдол өгч байна. “Гэр” хорооллын нүүрсээр галладаг зуухыг орлох нөөцлүүртэй цахилгаан халаагуурыг туршиж, дэлгэрүүлэх мөн холбогдох бодлого, тарифын урамшууллыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотын цэвэр агаар төслийн нэмэлт санхүүжилтийг боловсруулж байгаа болно.</p> <p>Багануур нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын нэг хэсэг ч гэсэн хотоос алслагдсан, чухамдаа хотын төвөөс 100 гаруй км-ийн алсад байрладаг. Гэсэн хэдий ч олон жижиг хот, тосгонд агаарын бохирдол асуудал болж байгаа бөгөөд шинэ станцын бохирдлын нөлөөллийг судлах нь зүйтэй. ДЦС нь Багануурын уурхайтай ойр байрладаг бөгөөд нүүрс нийлүүлэх тохиролцоо санал болгосон байгаа тул энэхүү асуудлыг ХНҮ-нд хамруулах ба уг үнэлгээ нь Төслийн нөлөөллийн бүсэд үзүүлэх уурхайн өргөтгөлийн хуримтлагдах үнэлгээн хамруулах үзэх зорилготой юм.</p> <p>МИНИС төслийн хүрээнд судалж буй нүүрснээс байгалийн хий (БХ) гаргаж авах судалгаа нь Улаанбаатар хотыг байгалийн хийтэй болгож, өвөлдөө халаалтын зорилгоор ашиглаж, халаалтын бус улиралд тээврийн хэрэгслийн</p> |

| | | |
|----|--|--|
| | эмээж буй юм. МИНИС төслийн хүрээнд судалж буй нүүрснээс шингэн гаргах байгууламжаас үүдэж болох сөрөг нөлөөллийн талаар бидэнд ямар нэгэн мэдлэг, мэдээлэл байхгүй байна. | түлшээр ашиглаж, улмаар энэ хоёр хэрэглээтэй холбоотой агаарын бохирдлыг бууруулах зорилготой юм. МИНИС төслийн вэб хуудаснаас цаашдын алхмуудтай холбоотой мэдээллийг авна уу: http://www.minis.mn/en/p/coal-to-synthetic-natural-gas . |
| 6 | Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг болон охид, эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэг нэмэгдэх эрсдэл: Охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрэгтэйчүүд давамгайлсан мянга, мянган ажиллах хүч Багануурт шилжин ирэхээс үүдэлтэй болзошгүй эрсдэлийн талаар бид санаа зовниж буй бөгөөд одоо Багануурт байгаа гадаад ажилчдаас үүдэлтэй энэхүү асуудал одоо ч байгаа. Одоогийн байдлаар Багануурын төмөрлөгийн үйлдвэрт ажиллаж буй 100 орчим хятад ажилчид нь охид, эмэгтэйчүүдэд нөлөөлж буй биеэ үнэлэх явдлыг нэмэгдүүлж буй бөгөөд энд ийм асуудал урд өмнө нь байгаагүй. Орон нутгийн засгийн газрын мэдээлсний дагуу Багануурын нүүрсний уурхайн өргөтгөл болон 700 МВ-ын ЦС-аас үүдэн уг дүүрэгт хятад ажилчид давамгайлсан нийт 3000-5000 ажилчид шилжин ирэх юм. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын хамрах хүрээнд жендэрийн нөлөөллийн үнэлгээ дурдагдаагүй бөгөөд бууруулах арга хэмжээ тусгах магадлал бага юм. | Удирдлага нь ажиллах хүч ихээр шилжин ирэхтэй холбоотой эрсдэлийг ялангуяа охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалтай холбогдуулан нухацтай авч үзэж байна. Хэдийгээр эдгээр эрсдэлүүд нь Төсөлтэй үзүүлж буй техникийн туслалцаатай шууд холбоотой биш боловч ХНУ-нд Хүсэлт гаргагчдын тавьсан санаа зовинож буй асуудлууд болон бусад ажиллах хүч ихээр шилжин ирэх асуудлуудыг авч үзнэ. Удирдлага нь Банкны шууд оролцоо байхгүй байсан ч гэсэн ийм эрсдэлүүдийг оновчтой үнэлж, бууруулах нь чухал болохыг Засгийг газрын анхааралд онцгойлон хүргүүлнэ. Ярвигтай уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд эрсдэл үүсэх нь сайн судлагдаж, нотлогдсон үр дагавар бөгөөд энэхүү эрсдэл нь Багануурын бүст аль хэдийнээ бий болсон юм. ХНУ-нд эдгээр эрсдэлийг авч үзэх бөгөөд Төсөлтэй холбоотой баримт бичгүүдээр цаашид үнэлэхийг зөвлөх магадлалтай юм. МИНИС төслөөс Багануурын станцад дэмжлэг үзүүлэхгүй байгаа боловч, Удирдлага нь барилгын ажлын үеэр ихээхэн хэмжээний ажиллах хүч шилжин ирэхээс үүдэх нийгмийн нөлөөллийн талаар зовниж буйгаа МУЗГ-тай яамны түвшинд хэлэлцэж, зохих арга хэмжээ авах нь зүйтэй гэж зөвлөсөн. Банк нь уурхайн өргөтгөл болон ДЦС-тай холбоотой нийгмийн асуудлуудыг судлах зорилгоор нийгмийн хамгааллын томилгоот багийг 2018 оны 1-р сард Багануурт ажиллуулсан. Томилгоот баг орон нутгийн Эмэгтэйчүүдийн холбоо болон бусад ТББ-уудтай уулзсан. Тэдгээр оролцогч талууд гадаадын ажиллах хүч шилжин ирэхтэй холбоотой асуудлуудыг хөндсөн.12 Банк нь ийм асуудлуудыг нухацтай авч үзэх шаардлагатай гэдгийг Зээлдэгчид онцолсон бөгөөд ХНУ-г хянах талаар явуулах яриа хэлэлцээрийн хүрээнд эдгээр асуудлаар Зээлдэгчтэй үргэлжлүүлэн хэлэлцэх болно. Удирдлага нь ДЦС-ын эхний ээлжийн ажилчдын баазыг барьсан боловч барилгын ажил түр зогссон гэж ойлгож байна. Уурхайн өргөтгөлийн барилгын ажил эхлээгүй байгаа болно. |
| 7. | АД-т жендэрийн нөлөөллийн үнэлгээ дутагдалтай тусгагдсан: Бид охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлүүдийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн боловч сүүлийн үед явагдсан мэдээлэл, хэлэлцүүлгийн ажилд аливаа нэг жендэрийн нөлөөллийн үнэлгээний талаар дурдаагүй болно. | Төсөлтэй холбоотой жендэрийн болзошгүй нөлөөллийг ХНУ-нд үнэлнэ. Шинэчилсэн ХНУ-нд энэхүү асуудлыг стратегийн түвшинд үнэлэх бол нүүрсний уурхайн өргөтгөлтэй холбоотой тухайлан боловсруулах БОННУ-нд нарийвчилсан зөвлөмжүүдийг тусгана. ХНУ-г боловсруулж дуусмагц ТЭЗҮ-г шинэчлэх болоод Зээлдэгчийн зүгээс шинэчлэн боловсруулах Багануурын Эцэслэн боловсруулсны дараа, ХНУ нь ТЭЗҮ-г шинэчлэн найруулж, өөрчлөлт оруулах болоод Монголын хуулийн дагуу 2018 оны эцэс гэхэд Зээлдэгчийн зүгээс БОННУ-нд оруулахаар төлөвлөсөн өөрчлөлтөд шаардлагатай мэдээллээр хангах юм. |
| 8. | Нийгэм болон жендэрийн нөлөөлөл: Улаанбаатар хотын агаарын бохирдол гамшгийн түвшинд хүрсэн байгаа тул бид Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлыг байгаль орчин болон нийгмийн | Төсөлтэй холбоотой нийгэм ба жендэрийн нөлөөллийг ХНУ-нд үнэлнэ. Зүйл 7-д өгсөн хариултыг харна уу. |

| | | |
|-----------|--|---|
| | <p>бодлоготой нийцүүлэн хийж буй эсэх, тэр дундаа агаарын бохирдол нэмэгдэх эрсдэл болоод одоо гамшгийн түвшинд байгаа хүн амын эрүүл мэнд, охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд үзүүлж болзошгүй эрсдэлүүдийг шинжлэн судалж буй эсэх дээр хянаж үзэхийг Хяналтын хороонд хүсэмжилж байна.</p> | |
| <p>9.</p> | <p>Уур амьсгалын өөрчлөлт: Монгол Улсын Үндэсний зорилтот хувь нэмрийг харгалзан үзэж бид “.....бусад боломжит хувилбарууд (үүнд “төсөлгүй хувилбар” орно) болон Монгол Улс болон ДБГ-ийн аль алины олон улсын түвшинд өгсөн амлалт, бодлогуудтай харьцуулна” гэж ОР 4.01-д заасны дагуу энэхүү нүүрсний төсөл болон түүнтэй холбоотой байгууламжийн альтернатив хувилбаруудыг судалсан эсэхийг хянан үзэхийг Хяналтын хороонд хүсэмжилж байна.</p> | <p>Удирдлага нь Хүсэлт гаргагчидтай адил хүлэмжийн хийн ялгарлын асуудалд санаа зовниж буй болно. Ялгарлын асуудлуудыг ХНҮ-ний нэг хэсэг болгон үнэлнэ. Банк нь ХНҮ-нд тодорхойлсон аливаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахаар Зээлдэгчид зөвлөх болно. Зээлдэгч нь Монгол Улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар олон төсөл дээр Зээлдэгчтэй хамтран ажиллаж буй болно.</p> <p>Монгол Улс нь температур хасах 40°С хүрдэг хүнд хатуу өвөлтэй. Монгол Улсын дулаанаа голлон нүүрс түлдэг ДЦС, өрхийн хэмжээний зуух, жижиг болон том оврын уурын зуухаас ихэвчлэн үйлдвэрлэдэг. Монгол Улсын нийт хүн амын бараг тэн хагас нь амьдардаг Улаанбаатар хот нь Багануурын нүүрсний уурхайгаас голлох нүүрсээ татдаг хэд хэдэн ДЦС-аас дулаан үйлдвэрлэх буюу дээрхтэй адилаар төвлөрсөн дулаанаар хангадаг. Сүүлийн 20 жилд эрчимтэй тэлж ирсэн уг хот нь социализмын үед баригдсан ч одоо ажиллаж буй ДЦС-д найдсан хэвээр байна. Шинэ дулааны цахилгаан станц болох ДЦС-5 төсөл нь дулаан болон цахилгааны системийн ачааллыг багасгах зорилготой байсан бөгөөд Багануураас нүүрснийхээ зарим хэсгийг авахаар байсан. ДЦС-5 төсөлд концессын гэрээ хийсэн бөгөөд АХБ-наас зарим санхүүжилтээ авахаар байсан боловч саяхан түүнийг цуцалж, оронд нь ДЦС-3 болон ДЦС-4-ийг өргөтгөхөөр болсон.</p> <p>Эрс тэс уур амьсгал, өвлийн улирал дахь халаалтын эрэлт хэрэгцээ болоод Монголын дотоодын нөөцийг харгалзан үзвэл нүүрс нь цахилгаан болон дулаанд ач холбогдолтой хэвээр байх бөгөөд нүүрсний уурхайг хөгжүүлэх нь өсөлтийн хүчин зүйл хэвээр байх юм.</p> <p>Багануурын нүүрсний уурхайг МИНИС төслийн хүрээнд судлагдах бөгөөд МИНИС төслийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд санал болгож буй хөрөнгө оруулалт болгон тодорхойлсон юм. Захирлуудын зөвлөлөөс баталсан МИНИС төслийн үнэлгээний баримт бичиг (ТҮББ) болон МИНИС төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн баримт бичгийн хүрээнд гурван зүйл хийсэн:</p> <ul style="list-style-type: none"> i) Нүүрсний олборлолтыг өсөлтийн хүчин зүйл хэмээн тусгайлан тодорхойлсон: “Орон даяар эрдэс баялгийн олон илэрц байгаа боловч Монгол Улсын Засгийн газар нь Оюутолгой (ОТ)-н алт, зэсийн орд, Таван толгой (ТТ)-н нүүрсний орд, Нарийн сухайт болон бусад гэх зэрэг Өмнийн говийн томоохон ашигт малтмалын ордыг хөгжүүлэхээр шийдсэн. Энэхүү улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд хамгийн их боломж бололцоо олгож буй салбар нь эрдэс баялгийн арвин их нөөц болох юм гэдгийг ихээхэн хүлээн зөвшөөрөгдсөн.” ii) Нүүрсний олборлолт болон нүүрс түлэх цахилгаан станцтай холбоотой тавьсан хүсэлтийг тусад нь ялгаж, салгасан: “Хэрэв хэрэгжилтийн явцад Зээлдэгч нь нүүрс түлэх цахилгаан станцын ГЭЗҮ хийх техникийн туслалцаа авах хүсэлт гаргавал Банкны Дээд Удирдлага тухайн хүсэлтийг нэг бүр хянаж үзэх |

| | | |
|----|---|---|
| | | <p>бөгөөд ингэхдээ Банкны 2010 онд батлагдсан Хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн ерөнхий стратегийн баримт бичигт хамаарах Нүүрсний төслийг шалгаруулах үйл ажиллагааны удирдамжийг баримтална.” (ТҮББ х. 51)</p> <p>iii) Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийг МИНИС төслөөс судалгааг нь санхүүжүүлэх санал болгож буй хөрөнгө оруулалт болгон тодорхойлсон. (Төслийн баримт бичиг, х. 3)</p> <p>Гэсэн хэдий ч МИНИС төслийн хүрээнд хийхээр төлөвлөсөн ХНУ болоод хамгийн зардал багатай эрчим хүчний судалгаа нь МУЗГ-т нүүрсний уурхайн өргөтгөл, эрчим хүчний хэрэгцээг хангах хувилбаруудын талаар байгаль орчин, нийгмийн өртөг, үр ашиг болон давуу, сул талуудтай нь хамт харгалзан үзэхэд удирдамж болно.</p> <p>Монгол Улс нь Парисын хэлэлцээрийн хүрээнд амласан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ҮЗТ-гөө хангахтай холбоотой томоохон бэрхшээлүүдтэй тулгарч байгаа бөгөөд Банк нь МУЗГ-ын ахалсан ҮЗТ-ний түншлэлд ДБГ-ийн оролцоог бий болгох замаар МУЗГ-т тэдгээр зорилтот түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлж буй юм. ДБГ нь МУЗГ-ын 100,000 нарын гэр хөтөлбөрт дэмжлэг үзүүлсэн бөгөөд одоогийн байдлаар сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх үүднээс баруун аймгуудад 10МВ-ын нарны цахилгаан станц барьж, шугамын холболт, тарифын асуудлыг хянан үзэж байгаа бөгөөд Улаанбаатар хотын гадна байрлах салхины станцад хөрөнгө оруулсан юм. Банк нь дулааны салбарын үр ашгийг нэмэгдүүлэх техникийн туслалцаа мөн үзүүлж буй юм. Түүнчлэн МИНИС төсөл нь хоёр боломжит усан цахилгааны хөрөнгө оруулалттай холбоотой судалгааг дэмжиж байна. МУЗГ нь сэргээгдэх эрчим хүчний стратегийн чиглэлээр дэмжлэг авах хүсэлт гаргасан ба Банкны зүгээс энэхүү хүсэлтийн дагуу яриа хэлэлцээр хийхэд бэлэн байна</p> |
| 10 | <p>ДБГ-ээс санхүүжүүлж буй стандарт хангахгүй ажил: Багануурын уурхайн өргөтгөлийн 2015 оны стандарт хангахгүй хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг сайжруулахад зарцуулж буй хугацаа, хүчин чармайлтыг харгалзан үзэн одоогийн зөвлөх нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг Дэлхийн Банкны бодлоготой зөвхөн процессын хувьд биш техникийн чанарын стандартын хувьд нийцүүлэн ажиллах техникийн чадавх болон туршлагатай эсэхийг хянаж, шалгана уу.</p> | <p>Удирдлага нь ХНУ-г шинэчлэхэд шаардаж буй хугацаа нь ХНУ-ний анхны төслийн эсхүл түүнийг шинэчлэхэд хийж буй ажлын чанар мууг илтгэх үзүүлэлт гэж санаа зовниж буй Хүсэлт гаргагчидтай санал нэг биш байна.</p> <p>Энэхүү ХНУ нь өөрөө томоохон газар нутаг хамарсан байгаль орчны болон нийгмийн олон асуудлыг хөндсөн ярвигтай ажил юм. Төслөөс ХНУ-г шинэчлэх зөвлөхийг авч ажиллуулж буй юм. Удирдлага нь уг зөвлөхийг энэ судалгааг эцэслэн боловсруулах чадавх, туршлага хангалттай гэж үзэж байна. Гэсэн хэдий ч энэхүү ХНУ-ний судалгааны хамрах хүрээ өргөн бөгөөд ярвигтай тул хэд хэдэн удаа үүнийг хянаж үзэх, шинэчлэх нь гайхах зүйл биш юм. ХНУ-г шинэчлэх болсон бас нэг шалтгаан нь хэлэлцүүлгийн үеэр илэрхийлсэн оролцогч талуудын саналыг тусгах явдал юм. Банк нь ХНУ-ний хэдэн удаагийн төслийг хянаж, саналаа өгсөн. Банк нь ХНУ-г хангалттай гэж үзэх хүртлээ хянаж үзэх процессыг үргэлжлүүлнэ.</p> |
| 11 | <p>Хуурамч хэлэлцүүлэг: МИНИС төслөөс явуулсан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээтэй холбоотой өмнөх хэлэлцүүлгүүд нь а) нөлөөлөлд өртөх иргэд болон эмзэг бүлгийн холбогдох оролцогч талуудыг хамруулаагүй; б) болзошгүй сөрөг нөлөөллийн талаар мэдээллийг ил болгож, бууруулах арга хэмжээний талаар хэлэлцүүлээгүй тул бид МИНИС төслийг мэдээлэл ил</p> | <p>Банк нь МИНИС-ийн ТУН-ийн оролцогч талуудын оролцоог хангах чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр Зээлдэгчтэй хамтран ажиллаж ирсэн бөгөөд үүний үр дүнд 2015 оны Хяналт шалгалт явуулах хүсэлтээс хойш нэлээдгүй ахиц гарсан. Удирдлага нь Зээлдэгч энэхүү чадавхаа ашиглан цаашид зохих ёсны оролцогч талуудын хэлэлцүүлэг явуулна гэдэгт итгэлтэй байна</p> <p>Зүйл 1 болон 3-т өгсөн хариултыг харна уу.</p> |

| | | |
|--|---|--|
| | <p>болгож, нөлөөлөлд өртөх иргэд болон бусад холбогдох оролцогч талуудад хэл, хэлбэрийн хувьд ойлгомжтой мэдээлэл бэлтгэж, хүргүүлэх байдлаар бодит хэлэлцүүлэг явуулахыг бодлого, журмыг дагаж мөрдүүлэх арга хэмжээг ДБГ-ийн Удирдлагаар авхуулахыг Хяналтын хорооноос хүсэмжилж байна.</p> | |
|--|---|--|

ХАВСРАЛТ 2
ГОМДОЛ БОЛОН ХАРИУЛТ – Хүсэлт 18/03

| № | Гомдол | Тайлбар |
|----|---|--|
| 1. | <p>Усны нөөц. Дэлхийн Банк нь орон нутгийн нөлөөлөлд өртөх иргэдэд түүний төслүүдээс үүдэж болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг ил болгож, хэлэлцүүлэхийг шаарддаг бодлогыг өөрийн төсөлдөө мөрдүүлж чадаагүйгээс үүдэн бид уламжлалт усны нөөцийг ашиглах боломжгүй болж болзошгүй байна (Монголын говьд). Монгол Улсын хамгийн өмнөд цэгт байрлах суурьшлын бүс болох Баянтэс сумын Хөвд, Хуршуутын баянбүрд болон түүний булгийн цогцолбор нь Алтайн-Өвөр говийн СГЗ, гүний усны сав газарт хамаарагддаг. Дэлхийн Банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (МИНИС төсөл)-ийн бүрэлдэхүүн хэсэг 3 нь Алтайн-Өвөр говийн СЗГ болон “усны нөөцийг хэрэглэж, хадгалах, усны аюулгүй байдлыг хангах, Говийн хүн амыг чанарын стандарт хангасан ундны усаар тасалдалгүй хангах, ус болон экосистемийг аж үйлдвэржилтээс хамгаалах стратегийн бодлогыг сайжруулах, экологийн балансыг хадгалахыг дэмжих” зорилготой тус сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг дэмжиж буй юм. Гэсэн хэдий ч тэд юу хийж байгаа талаар ямар нэгэн мэдээлэл өгөөгүй бөгөөд тэдний гаргасан тайланг нууцлалын зэрэгтэй гэж дэлгэхгүй байгаа тул одоо байгаа 6 нүүрсний уурхайгаас усны нөөцийн чанар, хэмжээнд үзүүлж буй нөлөөллийн талаар бидэнд мэдээлэл байхгүй байна. Одоо байгаа болоод ашиглалтанд орж буй 6-7 нүүрсний уурхайгаас үүдэлтэйгээр олон худаг, булаг ширгэсэн бөгөөд бид СГЗ нь усны нөөцийг хэрхэн удирдаж буй, нүүрсний уурхайнуудын хуримтлагдах нөлөөллийн</p> | <p>МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын дэмжлэг нь гүний усны мониторингийн сүлжээг бий болгох, 3 СГЗ-д болон 3 СГЗӨ-үүдийг байгуулах, цөөн тооны гүний усны үнэлгээ болон менежментийн судалгааг боловсруулах, ГДУММН-г байгуулах болоод 3 СГЗ-дын УННМТ-г боловсруулах ажлуудаас бүрдэнэ. СГЗ-д болон СГЗӨ-үүд нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа бүхий Монгол Улсын байгууллагууд юм.</p> <p>МИНИС төслийн үүрэг роль нь Өмнөговь аймаг дахь техникийн болон бусад мэргэжилтнүүдийн сургах, авч ажиллуулах болоод цалинжуулах, техникийн үнэлгээ, судалгааг санхүүжүүлэх болон захиргааны зардлын дэмжлэг үзүүлэх гэх зэргээр СГЗ-дыг байгуулж, чадавхыг бэхжүүлэх, СГЗӨ-үүдийг байгуулах юм. Уг дэмжлэгийн зорилго нь төрийн байгууллага болох СГЗ-д болон олон оролцогч талуудаас бүрдэх (үүнд иргэний нийгэм орсон) СГЗӨ-үүдээр дамжуулан уг бүс нутаг дахь усны нөөцийг хянах, усны оролцогч талуудын уялдааг хангах болон 2012 Усны тухайн хуульд заасанчлан хэд хэдэн УННМТ-г боловсруулахад тусалцаа үзүүлэх болно.</p> <p>Богинохон хугацаанд Өмнө говийн гурван СГЗ-д байгуулагдаж, гүний усны нөөцтэй холбоотой мэдээллийг нэгтгэж, олон оролцогч талуудтай харилцаж, гурван сав газарт УННМТ-г боловсруулж эхлээд байна. СГЗ-дын зарим нэг нь СГЗӨ-үүдийн адилаар нийтэд зориулсан вэб хуудастай.¹⁹ СГЗӨ-ийн уулзалтууд нь гурван сав газар тухай бүрд (Алтайн, Галба болон Умард) явагдаж, сав газарт тулгарч буй усны нөөцийн гол асуудлуудыг хэлэлцэх, өөрсдийн зовниж буй асуудлуудыг дэвшүүлэх боломжийг гол оролцогч талуудад олгосон. МИНИС төслөөс үзүүлсэн дэмжлэг нь Засгийн газар гүний усны нөөцийн талаарх мэдээллийг бүрдүүлэх, СГЗ-үүдээр дамжуулан оролцогч талуудад усны асуудлаар Засгийн газартай харилцах суваг бий болгох, эцэст нь УННМТ-нүүд болон холбогдох хэлэлцүүлгээр дамжуулан олон нийтэд илүү их мэдээлэл авах нөхцөлөөр хангахад чухал үүрэгтэй байсан.</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд үзүүлж буй дэмжлэгийн хоёр дахь чиглэл гүний усны бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой олон тооны янз бүрийн чиглэлийн жижиг техникийн судалгаануудыг санхүүжүүлж буй юм. Эдгээр тайлангуудад нь жижиг судалгаанаас авахуулаад техникийн үнэлгээ болон түүвэр судалгаа орж буй юм. Мэдээлэл нийтэд ил болгох шаардлага ОР/ВР 4.01-т техникийн судалгаа хамаарагдахгүй тул Төслийн БОНМХ-нд гүний усны судалгаа, чанарын үнэлгээ, түүвэр судалгаа, зураг, аргачлал болон судалгааны төлөвлөгөөг хамгааллын хэрэгсэл ашиглах эсхүл хэлэлцүүлэх болон олон нийтэд ил болгох шаардлагагүй гэж тодорхой заасан болно. Гэсэн хэдий ч Удирдлага нь МУЗГ-ыг аль болох их мэдээлэл ил болгохыг дэмжиж ирсэн ба МУЗГ-аас эдгээр судалгааны гурвыг нь нийтэд ил болгосон ба дөрөв дэхийг нь ил болгох эсэхийг авч хэлэлцэж буй юм²⁰. Эдгээр</p> |

¹⁹ <http://galba.gobiwater.mn/>; <http://altai.gobiwater.mn/>; https://www.facebook.com/galba.zuvlul/?ref=br_rs; https://www.facebook.com/umard.gobi?ref=br_rs.

²⁰ Эдгээрт: усны салбарын нэр томъёоны стандарт, гүний усны хайгуул хийх аргачлал болон ураны ордтой газар гүний усны судалгаа хийх аргачлал орно. Ил болгохоор харгалзан үзэж буй дөрөв дэхь судалгаа нь гүний усны хайгуулын нэгж төсөв тооцоолох удирдамж орно.

| | |
|---|---|
| <p>талаар бид санаа зовниж буй юм. Энд ямар нэг мэдээлэл өгөөгүй, хэлэлцүүлэг зохион байгуулаагүй. Мэдээллийг ил болгохгүй байх нь үнэлгээний ажлын дутагдалтай тал, эсхүл чанар муутай хуурамч үнэлгээний тайланг далдлах зорилготой байдаг практик түгээмэл тул бид санаа зовниж буй юм. СГЗ-ны хуудас дээр тавьсан мэдээлэлд 58 уул уурхайн лицензийг жагсаасан боловч зөвхөн 7 уурхайн усны хэрэглээг тайлагнасан байна. ХҮСНЭГТ РЕДАКЦЫН ЗАСВАР.</p> | <p>судалгаа болон тэдний ил болсон эсэх статусыг Хавсралт 3-аас харна уу.</p> <p>Нийтэд ил болгоогүй тайлангуудын зарим нь Монгол Улсын хуулийн дагуу нууцлалын зэрэгтэй гэж тооцогдох бөгөөд үүнд гүний усны дата мөн хамрагдаж буй юм. Энэ нь гүний усны датаг нууцлалын зэрэгт тооцож, нийтэд ил болгодоггүй Банкны харилцагч олон улс оронтой адил байгаа юм. Гэсэн хэдий ч Банкны зүгээс өөр судалгаануудыг Монгол Улсын хуулийг зөрчилгүйгээр ил болгох боломжтой эсэх талаар Засгийн газартай яриа хэлэлцээр өрнүүлж байна. Түүнчлэн сонирхож буй оролцогч талууд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд нууцлалын зэрэгтэй мэдээллийг авах хүсэлт гаргах замаар давж заалдах механизмыг МУЗГ бүрдүүлж өгсөн байдаг.</p> <p>МИНИС төсөл нь Өмнө говийн бүс нутгийн гурван сав газарт эхлээд СГЗ-д, дараа нь СГЗӨ-үүдийг байгуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх зэргээр оролцогч талуудын оролцоог дэмжихэд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд туслалцаа үзүүлэхээр ихээхэн хүчин чармайлт гаргасан. Банкны төлөөлөгчид Өмнө говьд болсон СГЗӨ-ийн анхны уулзалтанд ажиглагчаар оролцож, оролцогч талуудын оролцоо, дэмжлэг болоод хэлэлцүүлгийн чанарыг ажигласан. Жишээ нь Алтайн-Өвөр говийн СГЗӨ-ийн уулзалтууд 2016 оны 2 болон 9-р сар болоод 2017 оны 6 болон 11-р сард болсон. Умардын СГЗ-ийн уулзалт 2016 оны 12-р сар, 2017 оны 5 болон 11-р сард зохион байгуулагдсан. Галбын СГЗӨ-ийн уулзалт 2016 оны 4 болон 11-р сар, 2017 оны 5 болон 11-р сард зохион байгуулагдсан. МИНИС ТУН-ийн ажилтнууд эдгээр уулзалтын ихэнхэд оролцсон. СГЗӨ бүр анхны уулзалтанд оролцсон иргэний нийгмийн төлөөлөл, хувийн хэвшил болон бусад талуудын төлөөллөөс сонгогдсон 41-45 гишүүнтэй. Ээлжит уулзалт болохоос өмнө 15 хоногийн өмнө бүх гишүүдэд мэдэгддэг. Уулзалтаар жилийн төлөвлөгөө, хэрэгжиж буй үйл ажиллагаа, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэлэлцдэг бөгөөд ахицын тайлан, гүний усны загварчлалын ерөнхий асуудлууд, МИНИС төслийн үйл ажиллагаа болон тусгай төслүүдийн талаарх мэдээлэл, мониторингийн сүлжээ болон орц, Төслийн “Орхон” болон “Шүрэн”-гийн бүрэлдэхүүн хэсгүүдийг мөн хэлэлцсэн. Уулзалтын талаарх мэдээллийг СГЗӨ-ийн вэб хуудас болон нийгмийн сүлжээгээр тараадаг.</p> <p>МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд дэмжлэг үзүүлж буй гурав дахь чиглэл нь гүний усны мониторингийн сүлжээг Өмнөговь аймагт байгуулах, үндэсний хэмжээнд ГДУММН-ийг нэвтрүүлэх юм. Үүнд 44 мониторингийн шинэ цэг болон ирээдүйд мониторингийн зорилгоор тавих нэмэлт цэгийг тогтоох ажил хамарч буй юм. Түүнчлэн Төслийн хүрээнд төрийн байгууллагуудын янз бүрийн шатны албан хаагчид өөрсдийн ажилдаа хэрэглэхээр авч болох онлайн дата баазыг байгуулж буй юм.</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 3-ын дөрөв дэхь үндсэн чиглэл нь Өмнө говийн гурван СГЗ-дын УННМТ-г боловсруулахаар одоо явуулж буй ажил юм. УННМТ-нд нь бүс нутгийг хамарсан одоогийн усны нөөц, ирээдүйн чиг хандлага болоод усны нөөцийн менежменттэй холбоотой бусад олон асуудлыг ерөнхийлөн судална. Үүнд бүс нутаг дахь дэд бүтцийн төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн дүн шинжилгээ, усны нөөцийн хэрэглээнд гарах чиг хандлагын талаар мэдээлэл хамарч буй юм.</p> <p>Гүний усны менежментийн хувилбаруудыг үнэлэхэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамруулан үнэлэх шаардлагатай байж болох тул УННМТ-ний АД-т оролцогч талуудыг оролцуулж, хэлэлцэх ажлыг тусгасан бөгөөд энэхүү ажлыг Банкны бодлогод тусгасан шаардлагад нийцсэн байдлаар энэ</p> |
|---|---|

| | | |
|----|---|---|
| | | <p>оны сүүлээр хийхээр төлөвлөж байна. УННМТ-г боловсруулж буй зөвлөхүүд нь анхны оролцогч талуудтай уулзах ажлыг хийсэн. УННМТ-ний зөвлөх болгон өөрийн хариуцсан СГЗӨ-ийн уулзалтанд оролцсон. Түүнчлэн тэд тайлангаа боловсруулах зорилгоор сум, багийн засаг дарга, байгаль орчны мэргэжилтэн, орон нутгийн бизнесийн байгууллагууд, малчид болон ТББ-уудтай тусдаа уулзсан. УННМТ-ний ажлыг эхлүүлэх үед оролцогч талуудад хийсэн арга хэмжээний жагсаалтыг Хавсралт 4-өөс харна уу.</p> <p>СГЗ-дад зориулсан УННМТ-ний ажил одоо явагдаж байгаа бөгөөд тайлангийн төсөл бэлэн болмогц нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулна. УННМТ-г 2018 оны эцэс гэхэд хэлэлцүүлж, эцэслэсэн байхаар төлөвлөж байна.</p> |
| 2. | <p>Уурхай орчмын хүн амын дунд янз бүрийн өвчин гарах ихсэж буй, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлж, эмэгтэйчүүдэд үр зулбах, амьгүй ураг төрөх, ургийн хөгжил зогсох болоод генетикийн гажигтай хүүхэд төрөх асуудалтай тулгарч байна.</p> | <p>МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын дэмжлэгийн хүрээнд эдгээр асуудлуудын аль нь ч хамаарахгүй.</p> <p>Бидний үзүүлж буй дэмжлэг нь зөвхөн УННМТ-г боловсруулах ажлыг хамарч байгаа бөгөөд үүнд зөвхөн усны чанарын өөрчлөлтийн аливаа тогтоосон мэдээллийг тайлагнах ажил орж буй юм. Эдгээр төлөвлөгөөнүүд нь боловсруулалтын шатандаа явагдаж буй бөгөөд дээр дурдсанчлан нийтээр хэлэлцүүлгийн ажил хийгдэх болно.</p> |
| 3. | <p>Шинэ уурхайгаас үүдэх болзошгүй хор уршиг: Нүүлгэн шилжүүлэлт эсхүл ус авах боломжоо алдсаны нөхөн төлбөргүйгээр газар булаах ядвал.</p> <p>Гурвантэс сумын РЕДАКЦИН ЗАСВАР багуудад РЕДАКЦИН ЗАСВАР нүүрс олборлож эхлэхэд 30 малчин өрх болон 30 гаруй ногоочин өрхүүд нийт 60 гаруй өрх уламжлалт усны эх үүсвэрээ ашиглах боломжгүй болох магадлал өндөр байна. Бэлчээр болон ногооны аж ахуйн эрхлэх газар усгүйгээр эдийн засаг, соёл болон үе дамжин уламжлагдаж ирсэн өмчийн үнэ цэнээ алдана. Одоогийн байдлаар РЕДАКЦИН ЗАСВАР нь ямар нэгэн газрын зөвшөөрөл авалгүйгээр өөрийн лиценз бүхий газрын ойролцоо 2x2 хэмжээтэй нүх ухсан, лицензийн газраар таслагдах хуучин цэргийн ангийн замыг шинээр барих замын ажил эхлүүлэн ажиллаж байна. БОННУ-ний тайланг сөрөг нөлөөлөлд өртөх нутгийн иргэдээр хэлэлцүүлж, тэдний зөвшөөрлийг аваагүй. Энэхүү тайланд нутгийн иргэд уламжлалт газар болон усны нөөцөө алдана гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулахыг зөвлөсөн байна. Гэсэн хэдий ч уг компани нь дээр дурдсан төлөвлөгөөг боловсруулах юмуу хэлэлцүүлэлгүйгээр ажлаа эхэлсэн.</p> | <p>МИНИС төсөл нь Гурвантэс сум дахь аливаа нэг уул уурхайн төсөл эсхүл уул уурхайн лиценз олгоход шууд оролцоогүй.</p> <p>СГЗ-д болон СГЗӨ-үүдэд Төслөөс үзүүлэх дэмжлэг нь үндсэндээ чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн тул Төслөөс үзүүлж буй дэмжлэг болон Хүсэлт гаргагчдын дурдсан уул уурхайн лиценз олгох үйл ажиллагаа хооронд уялдаа байхгүй юм. Төсөл нь Гурвантэс суманд ямар нэг уул уурхайн хөрөнгө оруулалтад шууд оролцоогүй. Банк нь уул уурхайн тэдгээр үйл ажиллагаатай холбоотой өвчлөлийн эрсдэлийг удирдах эсхүл нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаанд ямар нэг үүрэг оролцоо байхгүй юм. СГЗ-д нь уул уурхай, хөдөө аж ахуй болон бусад салбарт тухайн төслийн ус ашиглах хэмжээнээс хамааран жил бүр ус ашиглалтын зөвшөөрөл олгоход чиглэгдсэн янз бүрийн үүрэг хүлээдэг. Томоохон төслүүд буюу өдөрт 100м3 -ээс дээш усны хэрэглээтэй (үүнд томоохон уурхайнууд орно) этгээдийн хувьд Байгаль орчны яамнаас төслийн ТЭЗҮ-г хянан үзэж, урт хугацааны зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэдэг. Түүний дараа яам нь захиргааны журмын хувьд зөвшөөрлийг СГЗ-аар дамжуулан олгодог. Өдөрт 50-100м3-ийн хэрэглээтэй төслүүдийн хувьд СГЗ-д өргөдлийг хянан үзэж, зөвшөөрөл олгох нь зүйтэй эсэх талаар аймгийн байгаль орчны газарт зөвлөмж хүргүүлдэг. СГЗ нь уул уурхай лиценз олгоход дэмжих эсхүл лиценз олгоход нарийн мэргэжлийн хяналт тавихад ямар нэг байдлаар оролцдоггүй болно.</p> |

| | | |
|----|--|--|
| | | |
| 4. | <p>МИНИС төслөөс үүдэх хор уршиг: техникийн шаардлага хангахгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй компаниудыг сонгон шалгаруулсан нь чанар муутай усны сав газрын үнэлгээ, сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулагдахад хүргэж буй ба энэ нь нутгийн иргэдийн гадаргын болон хөрсний усны нөөцийг бүхэлд нь алдагдахад хүргэж болох юм. СГЗ-ны чиг үүрэгт “хайгуулын болон ашиглалтын лиценз, бусад ижил эрх олгоход үндэслэл болгох СГЗ-ны дүгнэлт”-ийг гаргах эрх, үүрэг багтдаг. МИНИС төсөл болон СГЗ-ны мэдээлэл болон шийдвэрүүд ил болоогүй тул усны нөөц ашиглалтыг ТЭЗҮ болон БОННУ-нд хэрхэн тодорхойлсон, ямар зөвшөөрөл олгосон болохыг харах боломжгүй байна. Энэхүү СГЗ-наас бид нар шиг уламжлалт хэрэглэгч нарт нөлөөлөх ус ашиглах зөвшөөрлийг хэрхэн олгосон, хэрэв энэ СГЗ-наас олгоогүй бол энэ нүүрсний уурхайд хэн, хэзээ мөн хэрхэн олгосон болохыг мэдэх боломжгүй байна. Бидний зүгээс мөн л баталгаажуулах боломжгүй байгаа боловч олж сонссоноор СГЗ-ны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах тендер зарлагдаж, дараа нь техникийн шаардлага хангаагүй байгууллагыг сонгосон гэх гомдол ирж, цуцлагдан, 2017 онд дахин зарлагдсан боловч ямар нэг төлөвлөгөө боловсруулагдаагүй хэвээр байна. Галба-Өөш Долоодын СГЗ-ны хувьд тус сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахаар уурхайн лицензтэй компанитай гэрээ байгуулсан болохыг мэднэ. Түүнчлэн СГЗ-ны менежментийн төлөвлөгөөг боловсруулах зардал 50 саяас 350 сая төгрөг болж, өмнө жилүүдийнхээс 5-6 дахин нэмэгдсэн гэж сонссон боловч бидэнд ямар нэг төлөвлөгөөг хэлэлцүүлээгүй мөн/эсхүл танилцуулаагүй байгаа болно.</p> | <p>Банк нь Галба-Өөш Долоодын Говийн УННМТ-ний зөвлөхийг сонгон шалгаруулахад ямар нэг зөрчил гарсан гэх зүйл олж илрүүлээгүй.</p> <p>Энэхүү гэрээний тендерийг цуцалж, дахин зарлаагүй. Банк нь өөрийн тавьдаг тогтмол хяналтын хүрээнд Төслийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд мониторинг хийсээр байх болно.</p> <p>УННМТ-нд гүний усны олдоц, чиг хандлагын нэгдсэн үнэлгээг тусгах боловч “хайгуулын болон ашиглалтын лиценз, бусад ижил эрх олгох шийдвэр гаргахад үндэслэлийг боловсруулах” зорилгоор ямар нэг төсөлтэй холбоотой дүн шинжилгээ эсхүл мэдээллийг тусгахгүй болно.</p> <p>МИНИС төсөл нь ус ашиглах зөвшөөрөл олгохтой холбоотой чадавхыг бэхжүүлэх дэмжлэг үзүүлдэггүй болно. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон СГЗ-д нь ус ашиглах зөвшөөрөл олгох болон зөвшөөрөл гаргах явцыг хянадаг.</p> <p>Галба-Өөш Долоодын Говийн УННМТ-ний гэрээлэгч нь 2009 онд хугацаа нь дууссан уул уурхайн лицензтэй байсан бөгөөд лицензийн хамрах талбай нь УННМТ-ний судлах газарт хамаарахгүй, ашиг сонирхлын зөрчил байхгүй гэж ТУН-ээс Банкинд мэдэгдсэн болно.</p> <p>Дээр дурдсанчлан УННМТ-ний төслийн хэлэлцүүлгийг боловсруулалтын зохих шатанд хүрмэгц явуулах бөгөөд УННМТ-г 2018 оны эцэс гэхэд бэлэн болгохоор ажиллаж байна.</p> <p>Нийгэд ил болгосон МИНИС төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу УННМТ-нүүдийн төсвийг 110,000-150,000 ам.долларын хооронд тогтоосон байна. Энэхүү төсөв нь Засгийн газрын хийсэн тооцоо болон ийм судалгаа хийхэд шаардагддаг ажлын түвшинтэй таарч байгаа болно.</p> |
| 5. | <p>МИНИС төслөөс үүдэх хор уршиг: Дэлхийн Банкны төслөөс мэдээлэл ил болгохгүй,</p> | <p>Төсөл нь дээр дурдсанчлан гүний усны мониторингийг сайжруулах болоод мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх,</p> |

| | | |
|---|--|--|
| | <p>хангалттай зөвлөлдөхгүй байгаа нь компаниудад уламжлалт усны нөөцийг ашиглах бидний эрхийг зөрчих тааламжтай нөхцөл бүрдүүлж байна. Мэдээллийг ил болгохгүй байгаа нь компаниудад ямар нэгэн үндэслэх баримт бичиг үзүүлэлгүйгээр өөрсдийн усны нөөц ашиглах хэрэгцээгээ зөвтгөх эсхүл лицензтэй төсөлд бидний бэлчээр, ногоо тарьдаг газар, ойроос авдаг усны эх үүсвэрийг булаах зөвшөөрөл олгож байна. Энэ нь ДБГ-ийн нутгийн иргэдийн зохистой амьжиргаатай байх, хөгжих эрхийг хүндэтгэх талаар бодлогыг зөрчиж байгаагаас гадна Банкны ядуурлыг бууруулах чиг үүрэгтэй шууд зөрчилдөж байна.</p> <p>Мэдээллийг ил болгохгүй байх нь компаниудад СГЗ-наас гаргасан дүгнэлтгүйгээр эсхүл усны зөвшөөрөл үзүүлэлгүйгээр орон нутгийн усны нөөцөд ямар нэг хор уршиг учрахгүй гэж хэлэх боломжийг олгож байна.</p> <p>Тиймээс ДБГ-ийн төсөл нь бидний уламжлалт усны нөөц ашиглах эрхийг нүүрс олборлодог компаниудаар зөрчүүлэх таатай орчин бүрдүүлж байна.</p> | <p>оролцогч талуудаар хэлэлцүүлэх системийг бий болгоход дэмжлэг үзүүлж ирсэн.</p> <p>МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан нийтэд л бүх материалыг МИНИС төслийн вэб хуудас эсхүл www.estandart.gov.mn -т байршуулсан болно. Нэмэлт мэдээллийг Хавсралт 3-аас харна уу.</p> <p>Өнгөрсөнд явуулсан болоод төлөвлөсөн байгаа мэдээлэл ил болгох, хэлэлцүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Зүйл 1-т өгсөн хариултаас харна уу.</p> |
| 6 | <p>Гурвантэс суманд мэдээлэл ил болгохгүй, ямар нэг хэлэлцүүлэг явуулахгүй байгаа болоод МИНИС төслөөс олон нийтэд хүрч ажилладаггүй, стандартын шаардлага хангахгүй гүйцэтгэл нь ДБГ-ийн нутгийн иргэдийн зохистой амьжиргаатай байх эрхийг хамгаалахыг шаардсан бодлоготой нийцэхгүй байгаа тул Дэлхийн Банкны ядууралтай тэмцэх чиг үүрэгтэй шууд зөрчилдөж байна.</p> <p>Манай гүний усны нөөцийн сав газрын менежмент нь Дэлхийн Банкны МИНИС төсөлд хамрагдаж байгаа гэж бид мэдээгүй байсан тул өөрсдийн асуудлаар Дэлхийн Банкны удирдлага эсхүл бусад албан тушаалтнуудад хандаж байгаагүй юм. Гэсэн хэдий ч бидний түншүүд болох Оюу Толгой хяналт ТББ болон Хил хязгааргүй гол мөрөн ТББ нь Дэлхийн Банк болон түүний төсөлд мэдээллийн хүртээмжгүй байдлын талаар хандсан боловч</p> | <p>Дээр дурдсан СГЗӨ-үүдийн уулзалтуудаас гадна оролцогч талуудад хүрч ажиллах эхний арга хэмжээг УННМТ-г боловсруулах ажлын эхэнд гурван сав газарт зохион байгуулсан.</p> <p>Энэхүү уулзалтуудыг зорилго нь оролцогч талуудад УННМТ-г боловсруулах ажил явагдах гэж буй талаар анхааруулж, оролцогчдоос санал авах байсан юм.</p> <p>Дээр дурдсанчлан гурван УННМТ-ний төслүүдийг нийтээр хэлэлцүүлнэ. Удирдлага нь Төслийн нийтээр хэлэлцүүлэх шаардлагыг хангуулахын тулд Зээлдэгчтэй үргэлжлүүлэн ажиллах болно.</p> |

| | | |
|----|--|--|
| | <p>БОАЖЯ-нд ханд гэх хариу авсан.</p> <p>МИНИС-ийн ТУН-ид мэдээлэл авах хүсэлт тавьсан боловч БОАЖЯ нь СГЗ-дыг хариуцдаг тул БОАЖЯ-нд хүсэлтээ тавих зөвлөмжийг өгсөн (Хавсралт.....-ыг харна уу). МИНИС төсөл нь БОАЖЯ-наас мэдээлэл авахыг зөрчсөн нь үйл ажиллагаа явуулж буй орны хуулийг дагаж мөрдөхийг шаарддаг Банкны бодлогыг зөрчиж байна. Монгол Улсын хуульд нийтийн эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа эсхүл үзүүлж болзошгүй байгууллагын үйл ажиллагаа, технологийн талаарх мэдээллийг нууцад хамруулах мэдээллийг ангилалд оруулахыг хориглодог болно.</p> <p>2015 онд бидний хамтран гомдол гаргагч болох Хил хязгааргүй гол мөрөн эсвэл нь мэдээлэл ил болгохгүй, хэлэлцүүлэхгүй байгаа энэхүү асуудлаар гомдол гаргасан. Хяналтын хороо нь газар дээр хор уршиг учраагүй гэх үндэслэлээр хяналт шалгалт явуулахыг хойшлуулсан. Хоёр жилийн дараа буюу 2017 оны 7-р сард ОХУ болон Монгол улсад мэдээлэл ил болгох, хэлэлцүүлэг явуулах томоохон ажил хийсэн хэмээн төслийг хянаж, шалгахгүй байх шийдвэр гаргасан.</p> <p>Бидний нөхцөл байдал ондоо юм. СГЗ-ны усны нөөцийн менежментийн төлөвлөгөө байхгүй, ихээхэн хэмжээний нүүрс олборлолтоос бидний уламжлалт усны нөөцөд үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээллийг ил болгодоггүй, хэлэлцүүлэг явуулдаггүйгээс үүдэн бидний усны нөөцөд газар дээр шууд хор уршиг үүссэн болно.</p> | |
| 7. | <p>Бүрэлдэхүүн хэсэг 3-т хамаарагдах усны судалгаатай холбоотой ихэнх мэдээлэл Нууцлалын зэрэгтэй тайлангийн жагсаалтад орсон бөгөөд олон нийтэд ил болгоогүй. Үүнд “Гидрогеологийн судалгааны талаарх урт хугацааны төлөвлөлт”, “хуулийн болон институцийн тогтолцооны үнэлгээ”, “ул хөрсний гүний усны суурь судалгаа”, “усны аюулгүй байдлын дүн</p> | <p>Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан зарим материалын нууцлалын асуудлыг Зүйл 1-т өсөн хариултад дурдсан болно.</p> <p>УННМТ-ийг бэлэн болмогц гүний усны олдоц болон чиг хандлагын талаарх нэгдсэн мэдээллийг нийтэд ил болгож, хэлэлцүүлнэ.</p> <p>Шинэ уурхайн төсөлд лиценз олгоход Төсөл нь оролцдоггүй бөгөөд тухайн төслүүдээс үүдэж болзошгүй нөлөөллийн талаар хэлэлцүүлэг явуулах ёсгүй болно.</p> <p>Банк нь Галба-Өөш Долоодын Говийн УННМТ-ний</p> |

| | |
|---|--|
| <p>шинжилгээ”, “Сумын төв болон говийн 3 сав газарт хамаарах суурин газрын ус хангамжийн эх үүсвэрээс дээж авах, шинжлэх” гэх зэрэг орж байна. [...]</p> <p>Монгол Улс ДБГ-ийн бодлогыг мөрдөхөөс татгалзах болоод СГЗ-ын үйл ажиллагаа, Монголын өмнөд хэсэг (Говийн бүс)-ийн усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнүүдийн талаар мэдээллийг ил болгохгүй, мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах тухайн өөрийн хууль тогтоомжийг зөрчихийг хүлээн зөвшөөрснөөр Банк нь усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнүүдийг боловсруулах явцад Засгийн газар болон компаниудтай хамтран уламжлалт ус ашиглагчдыг ялгаварлан гадуурхаж буй гэж үзэж байна. Нутгийн малчидтай нүүрсний олборлолт, боловсруулалтаас тэдний усанд үзүүлж болзошгүй нөлөөлөл, аливаа бууруулах арга хэмжээний талаар зөвлөлдөөгүй, говьд амьдрахад нэн шаардлагатай нөөц болох усны нөөцийн талаарх шийдвэр гаргалтад оролцох бидний эрх зөрчигдөж байна. Мэргэжлийн шаардлага хангахгүй мөн/эсхүл уул уурхайн лицензтэй тул усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах даалгаварт ашиг сонирхлын зөрчилтэй зөвлөхийг сонгон шалгаруулсан нь ирвэс болон бусад нэн ховордсон амьтдын өлгий нутаг болох Тос, Тосон Бумбат тусгай хамгаалалттай газарт усны төлөөх шударга бус өрсөлдөөнийг бий болгож байна. (НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: Ирвэсний сангийн биологич Төмөрсүхийн Лхагвасүмбэрэл нь Гурвантэс сумын энэ хэсэгт нүүрсний олборлолтоос урьдчилан сэргийлэхээр оролдсоноос болж 2015 онд алагдсан.)</p> | <p>зөвлөхийг сонгон шалгаруулахад ямар нэг зөрчил гарсан гэх зүйл олж илрүүлээгүй.</p> |
|---|--|

| | | |
|----|--|---|
| 8. | <p>ДБГ-ийн 33-ийн гишүүдэд хүргүүлэх зөвлөмж</p> <p><i>Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй 6-7 нүүрсний уурхайн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийгээгүй, нүүрсний уурхайнууд боловсруулах үйлдвэр барьснаас усны хэрэглээ нэмэгдэж буй, усны экологи болон чанарыг аж үйлдвэржилтээс хамгаалах төслийн үүргээ хэрэгжүүлж чадаагүй, сэжиг төрөхүйц чанаргүй тендерийн процесс болон СГЗ-дын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнүүдийг боловсруулах ажил удааширалтай байгааг харгалзан үзэж, дараахыг 33-ийн гишүүдэд зөвлөнө үү, үүнд 1) МИНИС төслийн шийдвэр гаргах засаглалыг хянаж үзэх review; 2) МИНИС төслийн СГЗ-ны “усны нөөц ашиглаж, хамгаалах, усны аюулгүй байдлыг сайжруулах, Говийн хүн амд чанарын стандартад нийцэх ундны усаар хангах, ус болон экосистемийг аж үйлдвэржилтээс хамгаалах стратегийн бодлогыг сайжруулах болон экологийн тэнцвэртэй байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх” чиг үүрэгт үндэслэн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг боловсруулах 3) Олон улсын холбогдох стандартын дагуу усны ашиглалтын талаар шийдвэр гаргахаас өмнө үнэлгээний тайланг ил болгож, хэлэлцүүлэг явуулах тус тус орно.</i></p> | <p>Банк нь нийт төслийн хүрээнд Монголын хуульд заасан хоригийг зөрчилгүйгээр нэмэлт судалгааг ил болгох боломжтой эсэхийг судлах үүднээс Засгийн газартай хэлэлцэж буй болно.</p> <p>Ус ашиглалтыг үнэлэх Гурван СГЗ-дын УННМТ нь боловсруулагдаж буй, оролцогч талуудад чиглэсэн ажил явуулсан бөгөөд баримт бичгүүдийг боловсруулж дуусмагц хэлэлцүүлнэ.</p> <p>Холбогдох журмыг даган мөрдүүлэхийг тулд Банк нь МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ыг засаглалын зохицуулалтыг хянаж үзнэ.</p> <p>Боловсруулж буй УННМТ нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ биш боловч Өмнө говийн бүс нутаг дахь богино болон урт хугацааны усны нөөцийн прогнозыг шинжлэх бөгөөд үүнд урт хугацааны бодлого төлөвлөтөд ашиглах усны чанарын асуудлууд хамарч буй юм.</p> |
| 9. | <p>Дэлхийн Банкны удирдлага нь өөрийн бодлогуудыг даган мөрдүүлэхээр төсөлд хяналт тавих үүргээ биелүүлж чадаагүй (энэхүү тохиолдолд, ОР/ВР 4.01). Төслийн баг болон Банкны удирдлагад и-мэйл болон биечлэн асуудлыг тавьсан (Хавсралт хх-ийг харна уу) боловч тэдний хариулт, арга хэмжээ авах сонирхолгүй байдал нь Банкны бодлогыг мөрдүүлэх үүднээс хангалттай хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна.</p> | <p>Банкны баг нь МИНИС төсөлд ойроос хэрэгжилтийн дэмжлэг үзүүлж ирсэн. Сүүлийн 18 сард Төсөл нь нэн ялангуяа оролцогч талуудын оролцоог хангахтай холбоотой өөрийн гүйцэтгэлийг нэлээдгүй сайжруулсан.</p> <p>2015 оны Хяналт шалгалт явуулах хүсэлтийн хариуд явуулсан оролцогч талуудын оролцоог хангахтай холбоотой ажил ихээхэн сайжирсан нь ахицын нэг жишээ юм. Өөр сайжирсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ийн Зүйл 3-т өгсөн хариултаас харна уу.</p> |
| 10 | <p>Хүсэлт гаргагчид нь өмнө нь дангаараа болон хамтран хяналт шалгалт явуулах хүсэлтэй байгаа асуудлуудын талаар Удирдлага, Суурин</p> | <p>Дээр дурдсанчлан Төслийн хамрах хүрээ нь СГЗ-дын чадавхыг бэхжүүлэх болон өдөр дутмын үйл ажиллагааг дэмжихээр хязгаарлагддаг.</p> |

| | |
|---|---|
| төлөөлөгчийн газар, ТУН болон АХА нарт хандан мэдэгдэж байсан. Хүсэлт гаргагчид нь мэдээлэл ил болгохгүй, бодитой хэлэлцүүлэг явуулахгүй, ДБГ-ийн бодлогыг дагаж мөрдөхгүй байгааг үндэслэн МИНИС төсөлд хяналт шалгалт явуулах хүсэлт тавьж байна. Жишээлбэл, Оюу Толгой хяналт ТББ нь Алтайн-Өвөр Говийн СГЗ-ны талаарх мэдээлэл авах хүсэлт тавьсан боловч БОАЖЯ нь мэдээлэл ил болгох шийдвэрийг хариуцдаг хэмээн МИНИС төслөөс татгалзсан хариу өгсөн. | Гэсэн хэдий ч Банк нь Монгол Улсын хууль тогтоомжид заагдсан хоригийг зөрчилгүйгээр нэмэлт мэдээлэл ил болгох боломжтой эсэх талаар Засгийн газартай ярилцаж буй болно. |
|---|---|

ХАВСРАЛТ 3

МИНИС төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд боловсруулсан техникийн судалгаануудыг ил болгосон статус

| | Төсөв – ам.доллар | Ил болгосон талаарх тэмдэглэл |
|--|-------------------|---|
| Ил болгосон | | |
| Усны нэр томъёоны стандартыг шинэчлэн боловсруулах | 16,446 | Дараах холбоосноос төлбөртэй авах боломжтой: www.estandard.gov.mn . |
| Гидрогеологийн судалгаа, гүний усны нөөцийн үнэлгээний гарын авлага | 7,620 | Дараах холбоосноос авах боломжтой: www.minis.mn . |
| Ураны илэрцтэй газарт газрын доорх усны эрэл хайгуул хийх ажлын гарын авлага | 20,000 | Дараахаас авна боломжтой: www.minis.mn . |
| Нийтэд ил болгоогүй | | |
| Гидрогеологийн судалгааны талаарх урт хугацааны төлөвлөлт | 5,000 | Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүсэлт тавьж дотоодын иргэн, хуулийн этгээд авах боломжтой (гэхдээ гадаадын иргэн эсхүл хуулийн этгээд авах боломжгүй) |
| Хуулийн/институцийн тогтолцооны үнэлгээ | 22,600 | Засгийн газраас төслийг хянасны дараа ил болно. |
| Гүний усны ул хөрсний судалгаа | 88,204 | Монголын Улсын Улсын нууцын тухайн хуулийн дагуу нууцлалын зэрэгтэй. |
| Усны аюулгүй байдлын үнэлгээ | | Монголын Улсын Улсын нууцын тухайн хуулийн дагуу нууцлалын зэрэгтэй. |
| Гүний усны үнэлгээ явуулах - Баянхонгор аймгийн Шинэжинст сум | 539,000 | Монголын Улсын Улсын нууцын тухайн хуулийн дагуу нууцлалын зэрэгтэй дата. |
| Гүний усны судалгаа—Өмнөговь аймаг | 818,000 | Монголын Улсын Улсын нууцын тухайн хуулийн дагуу нууцлалын зэрэгтэй дата |
| Засгийн газраас нийтэд ил болгох эсэхийг хянаж буй | | |
| Гүний усны хайгуулын нэгж төсөв тооцоолох удирдамж | 16,934 | Статусыг Засгийн газраас хянаж буй |

| Хийгдэж буй судалгаа | | |
|-----------------------------|---------|---|
| УННМТ – Умардын сав газар | 113,000 | Боловсруулагдаж буй. Дэлхийн Банк-ны хэлэлцүүлэг болон нийтэд ил болгох бодлогыг дагаж мөрдөнө. |
| УННМТ – Галбын сав газар | 125,000 | Боловсруулагдаж буй. Дэлхийн Банк-ны хэлэлцүүлэг болон нийтэд ил болгох бодлогыг дагаж мөрдөнө. |
| УННМТ – Алтайн сав газар | 150,000 | Боловсруулагдаж буй. Дэлхийн Банк-ны хэлэлцүүлэг болон нийтэд ил болгох бодлогыг дагаж мөрдөнө. |

ХАВСРАЛТ 4

Усны нөөцийн нэгдсэн менежментийг төлөвлөх процессийн эхэн үед зохион байгуулсан оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт

| Байршил | Огноо | Уулзалтын зорилтууд | Оролцогчид |
|-------------------------------------|-----------|--|---|
| Алтайн Өвөр Говийн сав газар | | | |
| Эрдэнэ сум | 2017.5.21 | Сав газарт тодорхойлсон оролцогч талуудад УННМТ-г боловсруулах процесстой холбоотой мэдээллээр хангах; ус ашиглагч нарын талаарх чанарын болон тоон дата, хүн ам болон малын статистик дата цуглуулах, иргэдээс асуумж судалгаа авах, усны нөөцийг одоогийн ашиглалт болон хамгаалалттай холбоотой одоогийн асуудлууд гэх зэрэг УННМТ-ний төсөлд хамааралтай санаа зовниж буй асуудлууд, санал болоод байр суурийг сонсох. | Засаг дарга, Засаг даргын орлогч, байгаль орчны байцаагч, нийгмийн мэргэжилтэн, хүнсний аюулгүй байдлын мэргэжилтэн, мал эмнэлгийн газрын мэргэжилтэн, статистикийн мэргэжилтэн, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, байгаль хамгаалагч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд болон бусад оролцогч талуудыг хамарсан нийт 173 оролцогчид |
| Цээл сум | 2017.5.25 | | |
| Цогт сум | 2017.5.25 | | |
| Алтай сум | 2017.5.26 | | |
| Бугат сум | 2017.5.27 | | |
| Баянцагаан сум | 2017.5.06 | | |
| Баян-Өндөр сум | 2017.5.08 | | |
| Баянговь сум | 2017.5.09 | | |
| Шинэжинст сум | 2017.5.09 | | |
| Баянлиг сум | 2017.5.10 | | |
| Богд сум | 2017.5.10 | | |
| Номгон сум | 2017.6.05 | | |
| Хүрмэн сум | 2017.6.06 | | |
| Баяндалай сум | 2017.6.06 | | |
| Сэрвэй сум | 2017.6.07 | | |
| Ноён сум | 2017.6.07 | | |
| Гурвантэс сум | 2017.6.08 | | |

Галба-Өөш Долоодын Говийн сав газар

| Байршил | Огноо | Уулзалтын зорилтууд | Оролцогчид |
|--|------------------|---|---|
| Алтайн Өвөр Говийн сав газар | | | |
| Галба-Өөш Долоодын Говийн СГЗ ба түүний зөвлөл | 2016.10.13 | УННМТ-ний процессийг танилцуулах, сумын түвшинд ус ашиглалт, хэрэглээний мэдээлэл цуглуулах, устай холбоотой асуудлуудыг тодорхойлох, нийгмийн болон нийгэм, эдийн засгийн мэдээлэл цуглуулах, оролцогч талуудаас санал, зөвлөмж авах | Сумын Засаг дарга, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, байгаль орчин болон нийгэм, эдийн засгийн мэргэжилтэн, орон нугийн ТББ, иргэд болон Сав газрын захиргаад болон Сав газрын зөвлөл зэргийг хамарсан нийт 379 оролцогчид |
| Дорнод аймгийн ЗДТГ | 2016.12.02 | | |
| Өмнөговь аймгийн ЗДТГ | 2016.12.10 | | |
| Сүхбаатар аймгийн ЗДТГ | 2016.12.19-20 | | |
| Өмнөговь аймаг /8 сум/: Ханхонгор, Хүрмэн, Номгон, Баян-Овоо, Ханбогд болон Манлай сум | 2016.11.28-12.02 | | |
| Дорноговь аймаг /9 сум/: Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ, Зүүнбаян, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах болон Сайхандулаан сум | 2016.12.02-05 | | |
| Сүхбаатар аймаг /5 сум/: Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Наран болон Асгат сум | 2016.12.02-08 | | |
| Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Талын сав газар | | | |
| Улаанбаатар- БОАЖЯ болон МИНИС төсөл | 2016.9.20 | | |

| | | | |
|-------------------|------------|--|--|
| Багахангай дүүрэг | 2016.10.4 | Төслийн танилцуулга; ус | 78 оролцогчид: БОАЖЯ-ны төлөөлөгчид, Төслийн төлөөлөгчид, орон нутгийн шийдвэр гаргагчид, Сав газрын зөвлөл, иргэдийн төлөөлөгчид, ТББ, компани болон ус ашиглагч нарын төлөөлөгчид |
| Говьсүмбэр аймаг | 2016.10.05 | ашиглалтын дата цуглуулах; статистикийн дата цуглуулах; | |
| Дорноговь аймаг | 2016.10.06 | орон нутгийн иргэд, ТББ- | |
| Дундговь аймаг | 2016.10.07 | уудтай уулзах, асуумж судалгаа авах | |

ТАЙЛБАР: Энэхүү орчуулга нь Англи эхээс нь орчуулсан. Ямарваа нэг зөрүүтэй илэрхийлэл байх аваас Англи эхийг баримтлана. Энэ баримт бичгийн Англи хувилбар нь цорын ганц албан ёсны хувилбар болно.